

“Монголын текстилийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг - STeP EcoLab” төсөл

“ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САНХҮҮЖИЛТ” СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Банк, санхүүгийн байгууллагын ажилчид, сургагч багш нарт зориулав

АГУУЛГА

Танилцуулга	6
Сургалтын хамрах хүрээ, зорилго	6
МОДУЛЬ 1	7
ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ САЛБАР БА САНХҮҮЖИЛТ	7
Товч танилцуулга.....	7
1.1 Салбарын танилцуулга	8
1.2 Текстилийн тогтвортой үйлдвэрлэл гэж юу вэ?.....	12
1.3 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх асуудлууд.....	14
1.4 Ноолуурын нэмүү өртгийн сүлжээнд тогтвортой байдлыг бий болгох оролдлогууд	16
1.5 Санхүүгийн хэрэгцээ, боломж	17
МОДУЛЬ 1.Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #1	18
МОДУЛЬ 1 Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #2.....	18
МОДУЛЬ 2	20
ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	20
Товч танилцуулга.....	20
2.1 Олон улсын текстилийн тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлт, ногоон шошго.....	21
2.2 Текстилийн боловсруулах үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ.....	24
2.3 MNS Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын төсөл.....	29
2.4 MNS Хариуцлагатай малчин- зохистой дадал.....	31
2.5 Текстилийн салбарт баримтлах ToC-ийн удирдамж	34
2.6 Текстилийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлал.....	36
МОДУЛЬ 2. Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #3	39
МОДУЛЬ 3	41
ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН НОГООН ТӨСӨЛ, ЗЭЭЛ	41
Товч танилцуулга.....	41
3.1 Текстилийн салбарын ногоон санхүүжилт	42
3.2 Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлал	44
3.3 Баталгаажуулах арга: Ногоон шошго, гэрчилгээ	48
3.4 Бохир ус цэвэрлэх байгууламжийн жишээ.....	50
МОДУЛЬ 4	54
ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ	54
Товч танилцуулга.....	54
4.1 Туршилтын малчны ногоон зээл	55
4.2 ГОВЬ ХК-ийн тогтвортой үйлдвэрлэлийн туршлага.....	58
4.3 Текстилийн салбарын ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дасгал ажил #4.....	61
Дэлгэрүүлж судлах материал, холбоос	65

График, зураг, хүснэгтийн жагсаалт

График 1: Малын тоо толгой (сая).....	9
График 2: Түүхий эд үйлдвэрлэл (тонн), 2019.....	9
График 3. Суурилагдсан хүчин чадал ба үйлдвэрлэл (тонн).....	9
График 4. Монгол Улсын ноос, ноолуурын борлуулалт (сая.ам доллар).....	10
Зураг 1. Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээ	11
Зураг 2. Ноолуурын нэмүү өртгийн сүлжээ	11
Зураг 3. Монгол ноолуурын шинж чанар	12
Зураг 4. Ноос ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын шалгуурууд	15
Зураг 5. Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрэм (СДҮАД)-ийн шалгуурууд	15
Зураг 6. Тогтвортой ноос, ноолуурын санаачилгууд	16
Зураг 7. GOTS-ын шалгуурын тойм	22
Зураг 8. OEKO-TEX-ийн STEP-ийн шалгуурын тойм	23
Зураг 9. Монголын ноос, ноолуур боловсруулах салбарын байгаль орчин, нийгмийн халуун цэгүүд	25
Зураг 10. Хариуцлагатай нүүдэлчин мөшгих тогтолцооны хүрээ	32
Зураг 11. Хариуцлагатай Нүүдэлчид системийн шалгуур үзүүлэлтүүд	32
Зураг 12. БОНУС-ийн бүрдэл	36
Зураг 13. Текстилийн БОНЗ-ын аргачлалын процессын зураглал	36
Зураг 14. Текстилийн БОНЗ-ын эрсдэлийн аргачлалын шалгуур	38
Зураг 15. Текстилийн салбарын ногоон санхүүгийн эрэлт	42
Зураг 16. Ногоон санхүүжилтийн эх үүсвэр	43
Зураг 17. Текстилийн салбарт ногоон зээл олгох зураглал	45
Зураг 18. АСИТ ногоон шошго	49
Зураг 19. Говь ХК-ийн авсан OEKO-TEX гэрчилгээ	59
Зураг 20. Монголын Ноос Ноолуурын Холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэмд нэгдсэн батламж Error! Bookmark not defined.	
Зураг 21. Говь ХК-ийн авсан Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлын Мөнгөн батламж	60
Хүснэгт 1. Текстилийн үйлдвэрлэлийн ногоон хөрөнгө оруулалтын зээл, ерөнхий зориулалтаар	45
Хүснэгт 2. Текстилийн үйлдвэрийн ногоон эргэлтийн хөрөнгийн зээл, ерөнхий зориулалтаар	46

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

ААН	Аж ахуй нэгж
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МБАНХ	Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
МННХ	Монголын ноос ноолуурын холбоо
STeP EcoLab	Монголын текстилийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
СДҮАД	Сайн дурын үйл ажиллагааны дүрэм
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТоС	Тогтвортой санхүүжилт
ТТ	Тоног төхөөрөмж
ХХААХҮЯам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭХХ	Эрчим хүчний хэмнэлт

Европын Холбооны Европын Холбооны санхүүжилтээр SWITCH-Asia хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Монголын текстилийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг буюу STeP EcoLab” төслийн захиалга, санхүүжилтээр энэхүү гарын авлагыг Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо (ТОС Холбоо), сургагч багш нарын хамт гүйцэтгэв.

Төслийн тухай

Европын Холбооны санхүүжилтээр SWITCH-Asia хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Монголын текстилийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг буюу STeP EcoLab” төслийг¹ Agronomes et Vétérinaires Sans Frontières (AVSF) олон улсын байгууллагаас Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны төв (ТХҮХАТ, Герман), Монголын Ноос, Ноолуурын Холбоо (МННХ), Байгаль орчин, аюулгүй байдлын төв (БОАБТ), Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо (МБАНХ), Монголын Банкны Холбоо, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо)-той хамтран хэрэгжүүлж байна.

STeP EcoLab төслийн зорилго нь Монгол Улсын текстилийн салбарт байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээг бий болгоход оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд (i) зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тогтвортой баталгаажсан түүхий эд бэлтгэх боломжуудыг үүсгэх, (ii) текстилийн салбарын бизнесүүдэд байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийн арга туршлагыг нэвтрүүлэх таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, (iii) хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд Монголын текстилийн салбарын тогтвортой хөгжлийн санал санаачилгыг таниулах өргөн цар хүрээтэй ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

¹ Switch Asia Grants-аас дэлгэрэнгүйг үзнэ үү. https://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/grant_winners_7.pdf

Танилцуулга

Сургалтын модулиуд нь банк, санхүүгийн байгууллагын зээл, эрсдэл, ногоон санхүүжилт хариуцсан ажилтнууд, менежерүүдэд Монгол Улсын текстилийн салбарын онцлогийг ойлгох, үйлдвэрлэлийн ногоон төслүүдийг тодорхойлох, үнэлэх, ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх зохих мэдлэг чадварыг олж авахад текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн санхүүжилтийн талаарх онол, практикт суурилсан багц сургалтын хичээл, агуулга (модулиуд)–ыг боловсруулах зорилготой болно.

Сургалтын хамрах хүрээ, зорилго

Сургалтын хамрах хүрээ буюу зорилтот оролцогчид нь Текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, тогтвортой санхүү/ногоон банкны мэргэжилтнүүд, харилцааны менежерүүдийг сургагч багш нар, харилцааны менежерүүд/зээлийн мэргэжилтнүүд, бизнес/бүтээгдэхүүн хөгжлийн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтнүүд болон байгууллагын банк, жижиг дунд бизнесийн банк хариуцсан менежер/мэргэжилтнүүд байна.

Модулийн ерөнхий зорилго нь банк, санхүүгийн байгууллагын ажилчдын мэдлэг чадавхыг дараах хүрээнд нэмэгдүүлэхэд оршино:

- *Текстилийн салбарын харилцагч, бизнес, төслүүдийн тусгайлсан байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлийн үнэлгээ хийх*
- *Текстилийн ногоон машин тоног төхөөрөмжийг таних*
- *Текстилийн олон улсын болон монголын тогтвортой гэрчилгээжүүлэлт шошгыг таних*
- *Ногоон зээлийн шалгуур, аргачлалыг ашиглан бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх*

МОДУЛЬ 1.

ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ САЛБАР БА САНХҮҮЖИЛТ

Товч танилцуулга

Монгол Улсын нийт экспортын 10% орчмыг хөдөө аж ахуй (ХАА)-н салбар бүрдүүлдэг бол түүний 65% нь нэхмэл (текстиль)-ийн экспорт байна. 2020 онд цар тахлын нөлөөллөөс шалтгаалан ихэнх салбарууд буурсан үзүүлэлттэй байсан бол ХАА-н салбар 14%-ийн өсөлттэй гарчээ. Иймд текстилийн салбар нь манай улсын голлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбаруудын нэг ба харьцангуй савлагаа багатай, тогтвортой өсөлттэй, мөн газар дээрх шавхагдашгүй баялгийн нэг гэдгээрээ онцлогтой юм.

Гэсэн хэдий ч бэлчээрийн даац, экологийн тэнцвэрт байдал алдагдах зэргээс үүдэн байгаль орчин, уур амьсгалд сөрөг өөрчлөлтийг учруулах эрсдэлтэй. Үүсэж болох эрсдэлүүдийг үнэлэн түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, бууруулах, олон улсын болон үндэсний хэмжээний хөгжлийн бодлоготой хэрхэн уялдуулах, тогтвортой байдлыг үйлдвэрийн процесс, нэмүү өртгийн сүлжээнд хэрхэн ашиглах болон ямар санхүүжилтийн боломжууд байж болох зэрэг практик мэдлэгийг уг модулиар олж авна.

Цаашлаад энэ модульд текстилийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд банк, санхүүгийн байгууллагуудын мэдвэл зохих оролцогч талууд, ногоон санхүүжилтийн эрэлт, үүсэж болох эрсдэл, мөн салбарын ирээдүйн боломжийн талаар тусгагдсан.

Онцлох сэдвүүд:

- Монгол Улсын текстилийн салбарын өнөөгийн байдал
- Текстилийн тогтвортой үйлдвэрлэл гэж юу вэ?
- Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх асуудлууд
- Ноолуурын нэмүү өртгийн сүлжээнд тогтвортой байдлыг бий болгох оролдлогууд
- Санхүүгийн хэрэгцээ, боломж
- Оролцогч талууд ба санхүүжилтийн боломжийг бий болгох

1.1 Салбарын танилцуулга

Манай Улсын хөнгөн аж үйлдвэрийн орчин цагийн бүтээн байгуулалт 1934 оны эсгий, эсгий эдлэлийн үйлдвэр бий болсон цагаас хөгжиж ирсээр 1981 онд НҮБ-ын тусламжтай, Японы засгийн газрын санхүүжилттэй улсын үйлдвэрийн Говь компани байгуулагдаж монгол ноолуурыг боловсруулж эхэлсэн түүхтэй. 1990-ээд оны хувьчлалаас хойш улсын үйлдвэрүүд хувийн хэвшилд шилжсэнээр текстилийн салбар эрчимтэй хөгжсөн. Хөнгөн аж үйлдвэрийн салбарт 670 үйлдвэр ААН үйл ажиллагаа явуулж байгаагийн бараг тал хувийг нь текстилийн салбар эзэлж байна.

Монгол Улсын текстилийн салбарын дийлэнх хувийг ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэл эзэлдэг. Одоогийн байдлаар² энэ салбарт бүртгэлтэй 300 орчим үйлдвэр байдаг ба үүнд, 15 иж бүрэн цогцолбор үйлдвэр, 23 анхан шатны боловсруулах үйлдвэр, 59 сүлжмэлийн ЖДҮ болон 200 өрхийн жижиг цехүүд багтана (МННХ, 2020).


Монгол Улсын Засгийн газар ноолуурын үйлдвэрлэл нь эдийн засагт ихээхэн нөлөөтэй гэж үзэн 2000 оноос хойш уг салбарыг хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаа билээ. 2018 онд Ноолуур хөтөлбөр³-ийг шинэчлэн хэрэгжүүлж эхлүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60%-д хүргэж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж салбарын тогтвортой хөгжлийг бий болгохоор зорьж байна. Текстилийн салбарт хамаарах тогтвортой хөгжил, уур амьсгалын болон холбогдох гол бодлогын баримт бичгүүдээс дурдвал:

- Парисын хэлэлцээрийн дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC) (2016-2030), 2016 он
- Алсын хараа - 2050, 2020 он
- НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (SDGs)
- Монгол Улсын Ногоон Хөгжлийн Бодлого (2014-2030), 2014 он
- Ноолуур хөтөлбөр (2018-2021), 2018 он
- Мал аж ахуйн үндэсний хөтөлбөр: II үе шат (2016-2021), 2016 он
- Төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлого (2015-2030), 2015 он
- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022), 2017 он
- Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн замын зураг, 2018 он
- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2017 он
“УС” Үндэсний хөтөлбөр (2010-2015, 2016-2021)

Ноос, ноолуурын салбар нь текстилийн салбарын дэд салбар бөгөөд монгол ахуй, нүүдэлчдийн уламжлалт амьдралын хэв маяг - мал аж ахуйн менежменттэй хослуулсан Монгол Улсын байгаль орчин, эдийн засаг, нийгэмд ихээхэн холбоотой юм.

² <http://www.mongoltextile.mn/web/nav/79>


³ Ноолуур хөтөлбөр (2018-2021). <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol27.pdf>



Эх сурвалж 1. Үндэсний статистикийн хороо

Манай улсын 35,000 тонн ноос ба амьтны гаралтай ширхэгт үйлдвэрлэдэг. Үүний 9,400 тонн нь ноолуурын үйлдвэрлэл байгаа юм.

График 3. Суурилагдсан хүчин чадал ба үйлдвэрлэл (тонн)




Эх сурвалж 2. ХХААХҮЯ

Хөрөнгө оруулалт хийхэд зохистой үйлдвэрүүд:

- Суурилагдсан хүчин чадал ашиглалт 25-83% буюу хүчин чадлын хэмжээнд үйлдвэрлэж чаддаггүйн шалтгаан нь угаасан ноолуурын экспортод гаргадагтай холбоотой.

- Ээрэх үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал сүлжих нэхэхээс 2.8 дахин бага. Бүх ноолуурыг ээрэхийн тулд 2550 тонн ээрэх хүчин чадал нэмж суурилуулах хэрэгтэй.
- Одоо суурилагдсан сүлжих нэхэх үйлдвэрлэлийн хүчин чадлаар хонины ноосноос бусад нийт түүхий эдийн 1/7-ийг л боловсруулах боломжтой.

График 4. Монгол Улсын ноос, ноолуурын борлуулалт (сая.ам доллар)



Эх сурвалж 3. ХХААХҮЯ

Ноос ноолуурын борлуулалт жил ирэх тусам өссөөр байгаа боловч эцсийн бүтээгдэхүүний экспорт, дотоодын борлуулалт сүүлийн 3 жил төдийлөн хангалттай өсөөгүй байна (ХХАХҮЯам, 2019).

- **Монгол Улс** дэлхийн нийт ноолуурын 40%-ыг бэлтгэж, БНХАУ-ын дараа **дэлхийд хоёрт жагсдаг** (Дэлхий даяар 24 мян.тонн)
- Манай Улсын хувьд нэмүү өртөг шингээн эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаггүй ба нийт түүхий эдийн 80% нь хагас боловсруулагдаад экспортлогддог.
- Нийт ноолуурын борлуулалт 482 сая ам.доллар (2019), үүнээс **угаасан ноолуур 60%-г** эзэлж байна.
- Хэрвээ экспортод гарч байгаа угаасан ноолуурын 50%-ыг боловсруулж сүлжмэл цамц хийж экспортоор гаргавал экспортын орлого 472 сая ам.доллараар нэмэгдэн 954 сая ам.долларт хүрэх боломжтой.

Ноолуур нь байгалийн ховор түүхий эд бөгөөд хөнгөн, зөөлөн, дулаан хадгалах шинж чанараараа дэлхийд танигдсан, өндөр эрэлттэй түүхий эд юм. Ноос, ноолуур нь амьд амьтнаас гаралтай байгалийн гаралтай ширхэгт бөгөөд энэ нь бүтээгдэхүүн ба тогтвортой байдлын хэмжүүрийн хоорондох уялдаа холбоог бусад бүтээгдэхүүний ангиллаас

илүүтэйгээр хэрэглэгчдэд илүү тодорхой болгож, улмаар түүнтэй холбоотой сэтгэл хөдлөлийн холбоог бий болгож байдаг.

Зураг 1. Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээ




Зураг 2. Ноолуурын нэмүү өртгийн сүлжээ



Малчид, малчдын хоршоо, боловсруулах үйлдвэр, тээвэр логистик болон брэнд буюу дэлгүүрүүд гэсэн 4 тоглогч байдаг (Зураг 2).

Энгийн товчтой задгай цамц гэхэд 27 төрлийн технологийн дамжлагаар дамжин эцсийн бүтээгдэхүүн болдог.

Зураг 3. Монгол ноолуурын шинж чанар



Монгол ноолуурын онцлог:

- Уртлаг тул нарийн утас, даавуу хийхэд тохиромжтой
- Байгаль, цаг уурын байдлаас хамаараад олон төрлийн өнгөтэй ноолуур байдаг.

Эдгээр онцлогоос үүдэн гаднын үйлдвэрлэгчид манай ноолуурыг илүүтэй сонирхдог.

1.2 Текстилийн тогтвортой үйлдвэрлэл гэж юу вэ?

Текстил үйлдвэрлэлийн салбар 2015 оны байдлаар 1.2 тэрбум CO₂ ялгаруулсан үзүүлэлт нь дэлхий даяарх агаарын болон усан замын тээврийн ялгаруулж буй хэмжээнээс даруй 21 дахин их байна. Мөн дэлхий дээр гарч буй хаягдал усны 20% нь текстилийн салбараас гарч байдаг (Дэлхийн банкны судалгаа). Жилд 0.5 сая тонн нийлэг ширхэгт далай руу хаягдаж, 2000тн хортой химийн будаг Европын Холбооны орнуудын хөрсөнд нэвчдэг бол нийт хувцасны дөнгөж 1% л дахин боловсруулалтад ордог байна.

Уламжлалт текстилийн үйлдвэр байгалийн асар том бохирдуулагч учраас гол гарц нь байгаль орчинд ээлтэй нийгмийн хариуцлагатай текстилийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллахын тулд нэг талаас төрийн бодлогоор байгаль орчны хор хөнөөлийг нь бууруулахад зориулж бүх төрлийн торгууль, татварын зохицуулалт хийх, нөгөө талаас ногоон санхүүжилтээр дэмжиж, үйлдвэрлэл талаас байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарал бага гаргахад нь технологи, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын дэмжлэг хэрэгтэй байна.

Текстилийн тогтвортой үйлдвэрлэл нь дараах **боломжийг бий болгодог**.

- ◆ Бүтээгдэхүүний чанарыг бууруулахгүйгээр компанийн үйл ажиллагааг сайжруулах
- ◆ Үйлдвэрлэгчдэд тавигдаж буй өнөөгийн шаардлага нь хэрэглэгчид болон байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, компанийнхаа эдийн засгийг тогтвортой байлгах
- ◆ Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн олон зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх

Иймд текстилийн үйлдвэрүүд, бизнесүүд тогтвортой байдлын стратегийг хэрэгжүүлснээр


- ◆ *Нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг бууруулах*
- ◆ *Бизнесийн нэр хүндээ өсгөх*
- ◆ *Шинэ зах зээлд нэвтрэх*
- ◆ *Үр ашигтай ажиллах зарчмаар зардлаа бууруулах*
- ◆ *Одоогийн хууль эрхзүй дүрэм, журамд тусгагдаагүй боловч ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг удирдах зэрэг давуу талыг бий болгох боломжтой.*

Монголын тогтвортой ноолуур гэж:

“Бэлчээр, байгальд ээлтэй, мал, амьтдын амьдрах орчин, тавлаг байдлыг тэтгэсэн нүүдлийн МАА эрхлэгчдээс гаралтай түүхий эдээр нийгэм, экологид ээлтэй зарчмаар боловсруулах үйл явцыг баталгаажуулсан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг хэлнэ гэнэ”

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын Тогтвортой Ноолуурын Платформ

Уг тодорхойлолтод орсон 7 зарчмууд нь:



1.3 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх асуудлууд

Дэлхийн дулаарал

Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн дулаарал, цөлжилт, хээрийн түймэр, усны хомсдол, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарцын бууралтыг бий болгож, дэлхийн өнцөг булан бүрд хэмжээлшгүй их хор хохирол, нөлөөг үзүүлж байна (IPCC, 2019). Энэ нь өнгөрсөн зуунд хүн төрөлхтний бий болгосон эдийн засаг, нийгэм, аж үйлдвэрийн үсрэнгүй хөгжлөөс үүдэлтэй бөгөөд цаашид бидний ирээдүйн хөгжил дэвшил, оршин тогтнох үндэс болсон экосистемд ихээхэн хор хөнөөл учруулах хандлагатай байна.

Үүний нэг тод жишээ нь **бэлчээрийн доройтол** бөгөөд бэлчээрийн талбайн 70 орчим хувь нь доройтсон байдалтай байна (NDC, 2016). Байгаль орчны асуудлууд нь үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой хүний үйл ажиллагаанаас шалтгаалан илүү хүндэрсээр байна. Ноос, ноолууран бүтээгдэхүүний түүхий эд нь мал аж ахуйгаас гаралтай байдаг тул хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын нэхмэлийн салбартай ихээхэн хамааралтай юм. Бэлчээрийн талбайг тогтвортой байлгахын сацуу текстилийн салбар дахь дотоодын ЖДҮ эрхлэгчдийг дэмжихийн тулд тус салбарт системийн өөрчлөлт хийх шаардлагатай.

Ноос, ноолуур боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчид байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүнд үнэ цэнэ нэмэх, нэмүү өртөг бий болгоход цөөнгүй бэрхшээлтэй нүүр тулж байна.

Текстилийн боловсруулах үйлдвэрлэлийн БОН-ийн асуудлууд

Ноос ноолуурын салбарын боловсруулах үйлдвэрлэлийн хувьд байгаль орчин, нийгэмд ээлтэй буюу тогтвортой үйлдвэрлэл рүү шилжихэд тулгамдаж буй үндсэн асуудал нь ААН-үүдийн техникийн болон эдийн засгийн чадавх дутмаг, тогтвортой байдлын үндэсний стандартууд, баталгаажуулалт хөгжөөгүй, тогтвортой үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалт сул байгаад оршино. Цаашилбал нэг удаагийн хуванцар сав баглаа боодлын хэрэглээ өндөр, эцсийн бүтээгдэхүүнд агуулагдах химийн бодисын үлдэгдлийг тодорхойлох чанарын хяналтын дэд бүтэцгүй, үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх, лагийг зайлуулах арга барил хоцрогдсон, ус, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэлт сул байгаа зэрэг нь текстилийн салбарт тогтвортой үйлдвэрлэлийг нэвтрүүлэхэд ногоон зээл, ногоон санхүүжилтийн хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг 4. Ноос ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын шалгуурууд



MNS 6891 : 2020 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд



Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрэм (СДҮАД)

Зураг 5. Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрэм (СДҮАД)-ийн шалгуурууд

Сав баглаа боодол	Химийн бодисын хэрэглээ	Нийгмийн хариуцлага
<ul style="list-style-type: none"> Нэг удаагийн хэрэглээнээс татгалзах Дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол Сав баглаа боодлын хэмжээг бууруулах Хуванцар сав баглаа боодлыг дахин боловсруулах 	<ul style="list-style-type: none"> Химийн бодисын бүртгэл Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ Ногоон химийн бодисын хэрэглээ Хориглосон химийн бодисууд Химийн бодисын агуулахын шаардлага Химийн бодис ашиглах апулгүй ажиллагааны заавар 	<ul style="list-style-type: none"> Хүний эрх Хөдөлмөрийн харилцаа сургалт Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр Хүчирхийлэл ялгаварлан гадуурхалтаас ангид байх Хөдөлмөрийн хөлс Эрүүл аюулгүй ажлын орчин

Эрчим хүчний хэрэглээ	Усны хэрэглээ	Үйлдвэрийн хаягдал ус
<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний хэрэглээг бүртгэх • Эрчим хүчний хэмнэлт • Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ • Агаарт дэгдэх хийн ялгарлыг бууруулах 	<ul style="list-style-type: none"> • Усны хэрэглээг бүртгэх • Усны хэмнэлт • Усыг дахин ашиглах • Агаарт дэгдэх хийн ялгарлыг бууруулах 	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн хаягдал усыг бууруулах, • Хаягдал усыг цэвэршүүлэх • Хаягдал усыг дахин ашиглах • Урьдчилан цэвэрлэх байгууламжийг стандартын дагуу барих • Хаягдал усны хоруу чанар стандартад нийцсэн байх

1.4 Ноолуурын нэмүү өртгийн сүлжээнд тогтвортой байдлыг бий болгох оролдлогууд

Монгол Улсын ноолуурын нэмүү өртгийн сүлжээнд тогтвортой байдлыг бий болгох олон санал санаачилга, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Тухайлбал,

Зураг 6. Тогтвортой ноос, ноолуурын санаачилгууд



STeP EcoLab төсөл

“Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг - STeP EcoLab” төсөл (2018-2022) нь Монгол Улсын текстилийн салбарт байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг бий болгохыг зорин ажиллаж байна.

Текстилийн салбарт олгох ногоон зээлийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан ТоС Холбоо нь дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- МУ-ын нэхмэлийн салбар дахь ногоон санхүүжилтийн зах зээлийн эрэлтийн судалгаа
- Текстилийн салбарт баримтлах тогтвортой санхүүжилтийн удирдамж (банкинд зориулсан)
- Текстилийн салбарын байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх аргачлал/хэрэгсэл (банкинд зориулсан)
- Текстилийн салбарт ногоон зээл олгох шалгуур, аргачлал
- “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн санхүүжилт” сургалтын гарын авлага

2021 онд хийгдэх болон хийгдэхээр төлөвлөгдөж буй ажлууд:

- Ноос, ноолуурын үйлдвэрийг боломжит ногоон санхүүгийн эх үүсвэртэй холбож өгөх техник туслалцаа, зөвлөх үйлчилгээ
- Тогтвортой ноос, ноолуурын үйлдвэрт ногоон санхүүжилт өгөх боломжтой дотоодын болон гадны хөрөнгө оруулагчдын замыг зураг боловсруулах
- Текстилийн салбарт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдэд ногоон төсөл, бизнес төлөвлөгөө бичих сургалт зохион байгуулах

1.5 Санхүүгийн хэрэгцээ, боломж

Дээрх асуудлууд дээр нэмээд ноос, ноолуурын чиглэлээр ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг дутагддаг. Текстилийн салбарын ЖДҮ эрхлэгчдийн Ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаагаар Монгол Улсын текстилийн үйлдвэрлэгчдэд олгох боломжит ногоон санхүүжилтийг 75 сая төгрөгөөр тооцсон болохыг тогтоосон. 2021 он гэхэд сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн гарцыг 2200 мянган ширхэг бүтээгдэхүүнээр нэмэгдүүлэх үндэсний Ноолуурын зорилтод хүрэхийн тулд ногоон санхүүгийн нийт зах зээлийн эрэлт 576 тэрбум төгрөгтэй тэнцэх шаардлагатай гэсэн тооцоо гарчээ. Тиймээс, дотоодын банк, санхүүгийн байгууллагууд тогтвортой нэхмэлийн төслүүдийг санхүүжүүлэх замаар илүү тогтвортой эдийн засгийн шилжилтийг дэмжихэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын ноос, ноолуурын ЖДҮ-ийн өрсөлдөх чадварт тулгарч буй гол сорилт нь дараах дөрвөн бэрхшээлийг хамарсан санхүүгийн хүртээмжийн асуудал юм. Үүнд:


- 1) ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээнд нийцэхгүй, хүрэлцээгүй зээлийн санал
- 2) Барьцаа хөрөнгийн өндөр шаардлага
- 3) Захиргааны төвөгтэй үйл явц
- 4) Санхүүгийн ойлголтуудын хязгаарлагдмал ойлголтууд

МОДУЛЬ 1.Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #1

Сэдэв: Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчин, нийгэм, эдийн засагт сөрөг ул мөр үлдээх эмзэг цэгүүдийг (hotspots) тогтоох

Нийт хугацаа

15 мин (10 мин багийн хэлэлцүүлэг, 5 мин үр дүн танилцуулах)



Заавар:

- Багийн гишүүд хоорондоо товч танилцах
- Текстиль буюу ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг өгөгдсөн үйлдвэрлэлийн төрлийн хүрээнд дээр жагсааж бичих
- Сөрөг ул мөр үлдээх эмзэг цэгүүдийг (hotspots) тогтоох буюу сөрөг нөлөө ихтэйг эрэмбэлэх
- Танилцуулга хийх хүнийг томилох
- Танилцуулга 1-2 минут хийх

Баг 1, 2 Малчид, бэлтгэн нийлүүлэгчид

Байгаль орчны асуудал	Нийгмийн асуудал	Эдийн засгийн асуудал

Тухайн үйлдвэрлэлийн шатны хувьд дээр дурдсан асуудлуудаас сөрөг нөлөө хамгийн их ихтэйг эрэмбэлнэ үү.

1. _____
2. _____
3. _____

МОДУЛЬ 1 Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #2

Оролцогч талууд ба урт хугацааны санхүүжилтийн боломжийг бий болгох

Нийт хугацаа

20 мин (15 мин багийн хэлэлцүүлэг, 5 мин үр дүн танилцуулах)

Заавар:

- Хуваарилагдсан оролцогч талын текстилийн салбарт ямар чиг үүрэгтэй талаар хэлэлцэх
- Урт хугацаанд тогтвортой ногоон санхүүжилт татахын тулд өгөгдсөн оролцогч тал ямар арга хэмжээ хэрэгжүүлж болох талаар хэлэлцэж даалгавар 2 shared document дээр бичих
- Танилцуулга хийх хүнийг томилох
- Танилцуулга 1-2 минут хийх

Оролцогч талуудын төлөөлөл, багийн хуваарилалт

Баг 1: Монголбанк (Санхүүгийн зохицуулагч байгууллагууд)

Баг 2: Арилжааны банкууд

Баг 3: ToC Холбоо

Баг 4: Төрийн агентлаг, яамд

Баг 5: Олон улсын санхүүгийн байгууллагууд, хөгжлийн байгууллагууд

Баг 6: Бусад санхүүгийн байгууллагууд (даатгал, зээлийн батлан даалтын сан)

Багаараа хэлэлцэх асуулт: Урт хугацаанд тогтвортой ногоон санхүүжилт татаж ирэхийн тулд оролцогч талууд (хуваарилагдсан талыг төлөөлж хэлэлцэх) юу хийх вэ?

МОДУЛЬ 2.

ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Товч танилцуулга

Текстилийн салбарт байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ийн асуудлуудыг харгалзсан тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлснээр ногоон технологи ашиглан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний гарц нэмэгдэх, улмаар экспортын бүтээгдэхүүний өртөг өсөх, нөгөө талаас байгаль орчинд учруулдаг сөрөг нөлөөллийг бууруулж байгальд ээлтэй үйлдвэрлэлээр дамжуулан цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжууд бий болно.

Энэхүү модулийн хүрээнд мал маллагаа, бэлчээрээс эхлээд боловсруулах үйлдвэрийг дамжин эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгчийн гарт очих хүртэлх шат бүр дээр байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх нь хэр ач холбогдолтой болохыг, мөн тогтвортой текстилийн төслийг олон улсад болоод манай улсад хэрхэн баталгаажуулдаг талаарх мэдлэгүүдийг олж авах болно.

Цаашлаад энэ модульд хариуцлагатай нүүдэлчдийг мөшгөх тогтолцоо, БОНЗ-ын үнэлгээний аргачлалыг банкны ажилтан зээлийн үнэлгээнд хэрхэн ашиглах зэрэг практик судалгаа, мэдээлэлтэй танилцана.

Онцлох сэдвүүд:

- Олон улсын стандарттай харьцуулсан Текстилийн боловсруулах үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
- Текстилийн салбарт баримтлах ToC-ийн удирдамж
- Текстилийн салбарын тусгайлсан БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлал
- Олон улсын текстилийн тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлт, ногоон шошго
- Монгол Улсын ноос ноолуурын салбарт онцлох ногоон гэрчилгээжүүлэлт



2.1 Олон улсын текстилийн тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлт, ногоон шошго

Текстилийн үйлдвэрлэлийн хамгийн нэр хүндтэй олон улсын болон дотоодын гэрчилгээ, сайн дурын үйл ажиллагааны дүрэм (СДҮАД)-ийг дор тайлбарлав.

Нэр	Лого	Тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт		Цахим хуудас
		Байгаль орчны	Нийгмийн	
Blauer Engel - Textiles				https://www.blauer-engel.de/en
Blued esign				
Fair Wear Foundation				www.fairwear.org
Global Organic Standard (GOTS)				https://www.global-standard.org
Naturtextil iVN certified BEST				www.naturtextil.de
OEKO-TEX Made in Green				www.oeko-tex.com
SA8000				www.sa-intl.org
Cradle to Cradle				www.c2ccertified.org
World Fair Trade Organization				wfto.com

Өгөөж, давуу талууд:

- ✓ Нийгэм, байгаль орчин, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг багасгах илүү үр дүнтэй үйл ажиллагааг эрчимжүүлэх
- ✓ Болзошгүй эрсдэлийг бууруулах
- ✓ Олон нийтийн дунд нэр хүндээ өсгөх
- ✓ Тогтвортой бизнесүүдийг дэмждэг шинэ худалдан авагч, хөрөнгө оруулагчдыг татах боломж
- ✓ Зах зээлд эзлэх хувь, бүтээгдэхүүний үнэ цэнийг хадгалах, нэмэгдүүлэх
- ✓ Зах зээлийн тогтвортой байдлын манлайлагч, анхдагч болох

Текстилийн салбарт хамгийн их хамааралтай гэрчилгээнүүд




Дэлхийн органик нэхмэлийн стандарт

Дэлхийн органик нэхмэлийн стандарт буюу GOTS³ нь эцсийн хэрэглэгчдэд найдвартай баталгаа өгөх зорилгоор нэхмэл материалын түүхий эдийг цуглуулахаас эхлээд байгаль орчин, нийгмийн хариуцлагатай үйлдвэрлэлээс шошголох хүртэл органик статусыг хангах шаардлагыг тодорхойлох зорилготой.

Стандарт нь дор хаяж 70%-ийн гэрчилгээтэй органик үсээр хийсэн бүх нэхмэл эдлэлийг боловсруулах, үйлдвэрлэх, савлах, шошголох, худалдаалах, түгээх ажлыг хамардаг. GOTS стандартаар нэхмэлийн үйлдвэрлэлийн байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг дараах 4 чиглэлээр үнэлдэг.

Зураг 7. GOTS-ын шалгуурын тойм



Эх сурвалж 4. GOTS

ОЕКО-ТЕХ-ийн STEP гэрчилгээжүүлэлт

ОЕКО-ТЕХ-ийн STEP ⁴ нь текстил, арьс ширний салбарын брэнд, жижиглэнгийн худалдаачид, үйлдвэрлэгчдэд зориулсан бие даасан баталгаажуулалтын систем юм. Гэрчилгээжүүлэлт нь байгаль орчны үзүүлэлтүүдээ илүү найдвартай, ил тод мэдээлэх хүсэлтэй бүх шатны боловсруулах үйлдвэрүүдэд тохиромжтой. Иймд текстилийн салбарын бүх төрлийн байгууллагуудыг гэрчилгээжүүлэх боломжтой юм.

Зураг 8. ОЕКО-ТЕХ-ийн STEP-ийн шалгуурын тойм



Стандартад (1) химийн менежмент, (2) байгаль орчны гүйцэтгэл (эрчим хүч, ус, хаягдал ус, CO₂), (3) байгаль орчны менежмент (бодлого, дүрэм журам), (4) нийгмийн хариуцлага, (5) чанарын менежмент болон (6) эрүүл мэнд, аюулгүй байдлын шалгууруудыг багтана.

MNS ISO 14001: 2020 Байгаль орчны менежментийн тогтолцоо

MNS ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар⁵ нь аливаа байгууллага байгаль орчны гүйцэтгэлээ сайжруулах зорилгоор мөрдөх байгаль орчны менежментийн тогтолцооны шаардлагуудыг тогтоодог. Энэхүү стандартыг мөрдлөг болгосноор тогтвортой хөгжлийн байгаль орчны тулгуур зармыг тэнцвэртэй байлгахад хувь нэмрээ оруулах зорилготой юм.

⁴ <https://www.oeko-tex.com/en/apply-here/step-by-oeko-tex>

⁵ <https://estandard.gov.mn/standard/v/4141>

Нордик эко тэмдэг (Nordic ecolabel)



Уг эко тэмдэг нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон хэрэглээнээс үүдэх байгаль орчны нөлөөг багасгах, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэгдэгчид хялбар сонгоход хувь нэмрээ оруулан ажиллаж буй дэлхийд танигдсан тэмдэглэгээ юм.

1989 онд Скандинавын орнуудад үүсэж, одоогоор 59 бүлгийн 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнд гэрчилгээ олгодог. Үүнд нэхмэлийн салбар багтах бөгөөд 2001 онд анхны шалгуурыг баталж 2018 онд шинэчлэн баталсны дүнд текстилийн дараах байгаль орчны асуудлуудыг хамарч байна. Эдгээр нь:

- Эрчим хүчний хэмнэлт бий болгох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг уур амьсгалын нөлөөг бага байлгах
- Байгалийн шавхагдах нөөц болон усыг хязгаартай ашиглах
- Байгаль орчин ба эрүүл мэндэд хоргүй химийн бодис ашиглах, тухайлбал, үнэртэн агуулаагүй угаалгын нунтаг хэрэглэх
- Түгээлт хийж буй тээврийн хэрэгслийн байгаль орчинд учруулах нөлөөг бууруулах.
- Oeko-Tex 100 стандартад нийцсэн эсвэл шошгожуулсан текстилийн бүтээгдэхүүнийг илүүтэй авдаг байх


2.2 Текстилийн боловсруулах үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ эрхлэгчдийн хууль эрх зүйн болон байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг дагаж мөрдөх түвшин ямар байгаа вэ?

Монголын ноос, ноолуурын салбарын байгаль орчин, нийгмийн болон тогтвортой байдлын асуудлуудын өнөөгийн байдлыг үнэлэхийн тулд Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны төв (CSCP) -тэй хамтран “STeP EcoLab” төслийн хүрээнд нөлөөллийн үнэлгээг хийсэн болно. Энэхүү судалгаанд ноос, ноолуурын салбарын томоохон болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 20 компани хамрагджээ.

Үнэлгээний тайланг ус ашиглах, химийн бодисын хэрэглээ, бохир ус, хатуу хог хаягдал, лаг, эрчим хүч, нийгмийн хүчин зүйл гэсэн 6 сэдэвт төвлөрөн боловсруулсан болно. Үнэлгээний хүрээ нь ОЕКО-ТЕХ-ийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэхмэлийн хоёр стандарт, тухайлбал GOTS ба Made in Green (MIG)-д тогтоосон тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдтэй нийцэж байна. Үнэлгээний үр дүн тойм:

Зураг 9. Монголын ноос, ноолуур боловсруулах салбарын байгаль орчин, нийгмийн халуун цэгүүд



Усны хэрэглээ

Үнэлгээгээс харахад Монголын ноос, ноолуур үйлдвэрлэгчдийн усны хэрэглээний хэмжээ нь нэхмэл бүтээгдэхүүний нэг кг тутамд м³-ээр хэмжихэд бусад эх сурвалжуудад мэдээлж буй ноосон нэхмэл бүтээгдэхүүний усны хэрэглээний хэмжээнээс дунджаар 1.6 дахин их байгаа нь тогтоогдсон.

Усны хамгийн хэмнэлттэй компаниуд нь угаах, цэвэрлэх чиглэлээр ажилладаг анхан шатны боловсруулагчид юм.

Полиэфир, хөвөн гэх мэт бусад нэхмэл эдлэлтэй харьцуулахад дэлхий даяар ноосон утасны хэрэглээ маш бага байдаг (2015 онд бүх үслэгийн 1% -ийг ээрэхэд ашигласан). Үүнээс шалтгаалан, ноосны байгаль орчны нийт нөлөөлөл бусад нийтлэг нэхмэл эдлэлтэй харьцуулахад бага байна. Гэсэн хэдий ч тогтвортой аргаар үйлдвэрлэсэн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа нь Монголын ноолуурын салбарыг ус хэмнэх, ашиглах шилдэг туршлагыг хэрэгжүүлэхэд уриалж байна. Энэ нь олон оролцогч компаниудын дагаж байгаа шинэ чиг хандлага билээ.

Тулгарч байгаа бэрхшээлүүд ба халуун цэгүүд (Дунд)

- Усны хэрэглээг зөв хэмжих, бүртгэх, хянах тал дээр дутагдалтай
- Зан төлөвийг өөрчлөх эдийн засгийн хөшүүрэг багатай

“STeP EcoLab” төслийн нэг зорилт бол салбарын усны хэрэглээг 5% бууруулах явдал юм.

Химийн бодисын хэрэглээ

Ерөнхийдөө Монгол Улсад нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг химийн бодисын дийлэнх нь OEKO-TEX тогтвортой байдлын шалгуураар GOTS ба MiG-тэй нийцдэг. Гэсэн хэдий ч хамгийн алдартай будгийн хоёр төрөл болох Lanaset ба Lanazol-ийн будгууд нь GOTS-ээс хориглосон урьдчилан-металжуулсан болон азо будгийн ангилалд багтдаг.

Хэрэв компани эсвэл ААН тогтвортой байдлын стандарт, эко-шошго авах өргөдөл гаргахаар шийдсэн бол тодорхой комплайнсийн шалгалтуудыг хийлгэх шаардлагатай. Одоогийн байдлаар үндэсний туршилтын лабораториуд шаардлагатай зарим төрлийн

нарийн мэргэжлийн шалгалтыг хийх хүчин чадал, чадваргүй тул хоруу чанар, биологийн задралын босго шинжилгээнд асуудал гарч болзошгүй юм.

Үнэлгээ хийгдсэн ихэнх компаниудад химийн бодисын талаарх зохих бүртгэл, тэдгээрийн нэрс байдаг боловч аюулгүй байдлын мэдээллийн хуудаснууд дутуу учраас мэдээлэл нь бүрддэггүй. Машины тос, тосолгооны химийн бодисын хувьд мөн адил байдаг. Аюултай химийн бодисыг хадгалах, шилжүүлэх, боловсруулах журам хангалтгүй байдаг баүнийг сайжруулах, илүү нарийвчилсан баримт бичиг боловсруулах хэрэгцээтэй байна.

Тулгарч буй Халуун Цэгүүд (Өндөр)

- Ашигласан химийн бодисын баримтжуулалт хангалтгүй
- Нийтлэг ашигладаг химийн бодисууд (Ланасет, Ланасол) нь азо будгийн ангилалд багтдаг.

Хаягдал ус

Бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах, дахин боловсруулах өнөөгийн чиг хандлага нэмэгдэж, нийтлэг туршлагыг үндсэнд нь сайжруулахгүй бол Монголын ноос, ноолуур үйлдвэрлэгчид тогтвортой байдлыг хангахад ноцтой асуудлуудтай тулгарна.

Одоогийн бохир ус цэвэрлэх арга барилууд нь хуучирсан эсвэл бараг байхгүй гэхэд болохоор байна. Дор хаяж одоогийн үнэлгээ, төсөлд хамрагдсан компаниудын хүрээнд ийн дүгнэж болно.

Үйлдвэрлэлийн хаягдал усыг төв цэвэрлэх байгууламжид хаяхаас өмнө тухайн газарт урьдчилж цэвэрлээгүй тул нэхмэлийн үйлдвэрүүд Төв хаягдал ус цэвэрлэх байгууламжийн ачааллыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгааг манай үнэлгээ нотолж байна. Анхан шатны боловсруулагчаас гарсан бохир ус нь булингар ихтэй байдаг бол COD ба рН-ийн хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрч болно.

Удахгүй хэрэгжиж эхлэх ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нөхцөл байдлыг сайжруулах төлөвтэй байна. Үүнийг болон үүнтэй холбоотой асуудлуудыг үйлдвэрлэгчид сайн мэддэг, тиймээс тэд үйлдвэрлэлийнхээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор бохир ус цэвэрлэх байгууламжид хөрөнгө оруулах / хамтран хөрөнгө оруулах сонирхолтой байна.

Тулгарч буй Халуун Цэгүүд (Өндөр)

- Бичиг баримтжуулалт байхгүй/хангалтгүй (Анхан шатны боловсруулагч компаниудаас бусад компаниудад нарийн хяналт байдаггүй, хаягдал усыг цэвэрлэгээ, хэмжилт, баримт бичгийн шалгалт хийхгүйгээр төв цэвэрлэх байгууламж руу хаяж болдог)
- Хаягдал усыг цэвэрлэх арга байхгүй/хуучирсан

Хатуу хог хаягдал, лагийг зайлуулах

Салбарын хэмжээнд хатуу хог хаягдлын менежментийг дагаж мөрдөх байдал нь ерөнхийдөө сайн байгаа ч хаягдал усыг цэвэрлэх асуудлын адилаар лагийг зайлуулах асуудал сайн шийдэгдээгүй байгаа.

Үнэлгээ хийсэн үйлдвэрүүдийн хатуу хог хаягдлын менежмент ерөнхийдөө ижил төстэй бөгөөд ихэнх компаниуд хог хаягдлыг долоо хоног бүр цуглуулж, хог хаягдлын цэгүүдэд хүргэдэг хог тээврийн компаниудтай гэрээ байгуулдаг. Үйлдвэрлэлийн талбайд хог хаягдлыг шатаах, булаах ямар ч тохиолдол гарахгүй.

Тулгарч буй Халуун Цэгүүд (**Бага** – хатуу хог хаягдал; **Өндөр** - лаг зайлуулах)

- Бичиг баримтжуулалт байхгүй/хангалтгүй
- Бохир усыг цэвэрлэдэггүй, төвийн цэвэрлэх байгууламжид хаядаг

Эрчим хүчний хэрэглээ

Монголын аж үйлдвэрлэл хүйтэн уур амьсгалаас шалтгаалан эрчим хүч их шаарддаг гэж үздэг. Түүнчлэн, засгийн газрын тогтоосон эрчим хүчний тарифын бага хэмжээ нь эрчим хүчийг гамгүй хэрэглэхэд түлхэц болдог бөгөөд одоогийн судалгаа нь энэ үзэгдлийг нотолж буй. Нэг кг бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний зарцуулалтын талаар цуглуулсан дата нь ихэвчлэн олон улсын жишигт багтсан байдаг. Тус үнэлгээ нь мөн оролцсон компаниуд дээр янз бүрийн эрчим хүчийг хэмнэх арга хэмжээнүүд хэрэгжиж байгааг илрүүлсэн ажээ.

Жижиг компаниуд нь хэрэглээний зардлаа хянахад хялбар байдаг учраас илүү үр ашигтай ажилладаг, харин томоохон компаниуд эрчим хүчийг хэмнэх олон боломжуудтай байдаг.

Текстилийн үйлдвэрүүдийн ерөнхий чиг хандлага нь маш эерэг байна. Үнэлгээ хийх явцад бүх том, дунд, жижиг компаниуд эрчим хүчний хэрэглээгээ багасгах сонирхолтой байсан бөгөөд эрчим хүчийг хэмнэх арга хэмжээнүүдийг аль хэдийн хэрэгжүүлж, эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэсэн хэдий ч хэрэгжүүлсэн эрчим хүчийг хэмнэх арга хэмжээний үр ашгийг ихэвчлэн үнэлдэггүй. Одоогийн үйлдвэрлэлийн нэгжийн үндсэн эрчим хүчний хэрэглээг тооцоогүй байна. Мэдээж, эрчим хүчний хэрэглээг хянах, түүнийг зохицуулах арга зүй дутагдалтай байна.

Үйлдвэрлэлийн карбон ул мөрийг тооцдог уламжлал байдаггүй. Айлчилсан компаниудын нэг нь ч ISO 14000 цуврал стандарттай болоогүй байсан. Иймд компаниуд эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилт дэвшүүлэн байгаль орчны багц бодлого, журмыг боловсруулах шаардлагатай байна.

Тулгарч буй Халуун Цэгүүд (**Дунд**)

- Хяналт, баримтжуулалт муу
- Шаардлагагүй том, муу тусгаарлагдсан орон зайг халаах
- Урсгалыг сэргээн засварладаггүй: ус, эрчим хүчний нэмэлт алдагдал

Нийгмийн шалгуур үзүүлэлт


Ерөнхийдөө, нэхмэлийн үйлдвэрлэлийн нийгмийн шалгуур дах халуун цэгүүд нь Оеко-Тех and GOTS стандартуудын гаргасан ажлын цаг, хангалттай цалин хөлс, ХАБЭА шалгууруудыг дагаж мөрдөхгүй байна. Томоохон аж ахуй нэгжүүд нь хөдөлмөрийн тухай үндэсний хууль тогтоомжийн дагуу илүү цагийг бүртгэдэг хэдий ч жижиг ААН-үүдэд илүү цагийг бүртгэх арга хэрэгсэл хангалтгүй байв. Шөнийн ээлжээр болон ажлын бус цагаар ажилладаг ААН-үүдэд илүү цагаар ажиллах цагийн хяналтыг сайжруулах системийг суурилуулсан байх ёстой. Зарим тохиолдолд цөөн ажилчид илүү цагаар ажилласны төлбөр олгосон эсэх талаар мэдээлэлгүй байсан. Ажилчид болон захиргааны хооронд зөрчилдөөнгүй харилцаа холбоог тогтооход ажилчид мэдээлэл, хууль, эрх зүйн мэдлэгтэй байх шаардлагатай.

Тулгарч буй Халуун Цэгүүд (Дунд)

- Ялгаварлан гадуурхалт, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг баримт бичиг, дүрмийн хэрэгжилт хангалтгүй
- Илүү цагаар ажиллах
- ХАБЭА-н муу менежмент
- Шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн хомсдол

2.3 MNS Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын төсөл

MNS текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандарт⁶-ын төсөл



Уг стандарт нь Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах зорилготой бөгөөд Монголын ноос, ноолуурын салбарын тогтвортой байдлыг хангаж ердийн аргаар боловсруулсан текстилийн бүтээгдэхүүнээс ялгарч, дэлхийн ноос, ноолуурын зах зээлд илүү сайн танигдах, борлуулалтыг нэмэгдүүлэх боломжийг олгоход оршино. Энэхүү баримт бичгийг даган мөрдсөнөөр Монголын ноос, ноолуурын үйлдвэрүүд өөрсдийн бүтээгдэхүүний байгаль орчин, нийгмийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр шаардлагатай бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаа харуулах юм.

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг ашигласан бөгөөд хэрэв эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

- MNS 1-1:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг. Техникийн ажлын журам,
- MNS 1-2:2006, Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг. Стандарт боловсруулах арга зүй,

⁶ <https://estandard.gov.mn/medee/v/185>


- MNS ISO/IEC 17065:2013, Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага
- MNS ISO/IEC 17067:2014, Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар,
- MNS ISO/IEC 17021-1:2016, Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг
- ISO 19011:2016 Удирдлагын тогтолцоонд аудит явуулах заавар,
- MNS ISO 14001: 2016, Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, ашиглах арга зүйн заавар,
- MNS 6390-2013, Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага,
- MNS 4288-1995, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага,
- MNS 6561-2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага,
- MNS 6809:2019, Ямааны ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөн нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн,
- MNS 3683:2015, Текстиль. Ямааны хялгасыг ялгасан ноолуур. Техникийн шаардлага,
- MNS 4950:2015, Текстиль. Тэмээний хялгасыг ялгасан ноос. Техникийн шаардлага,
- MNS 5563:2005, Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага,
- GLOBAL ORGANIC TEXTILE STANDARD (GOTS),
- STEP by OEKO TEX.

Текстилийн тогтвортой үйлдвэрт тавих шаардлагууд

Байгаль орчин	Нийгмийн хариуцлага	Мал амьтны эрх
Байгаль орчны бодлого CO ₂ -ын ул мөрийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, байгаль орчны бодлогодоо тусгах	Насанд хүрээгүй хүний хөдөлмөр Ялгаварлан гадуурхалт Доромжлол, хүчирхийллийн үл тэвчилт	Нүүдлийн мал аж ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлж, мал амьтны тавлаг байдлыг хангасан, гарал үүсэл нь тодорхой, тохирлын гэрчилгээтэй ноос ноолууран түүхий эдийг хүлээн авна.
Цэвэр ус	Цалин хөлс	
Бохир ус	Эрүүл мэнд хөдөлмөр хамгаалал	
Эрчим хүч (цахилгаан, дулаан, уур)		

Баталгаажуулалт - Монголын Ноос Ноолуурын Холбоо (МННХ)-ны баталгаажуулалтын алба

Гэрчилгээжүүлэлт нь A-D хүртэлх бүх үзүүлэлтүүдийг урт хугацаандаа биелүүлсэн байхыг шаарджээ.




D буюу Олон улсын стандартуудын шалгуурууд: Стандарт нь ноос ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг бий болгож олон улсын тэргүүлэх стандартуудад чиглэсэн амбиц бүхий арга зам хэдий ч нэр бүхий стандартуудын гэрчилгээжүүлэлт нь энэхүү СДҮАД ороогүй, илүү нарийн шалгууруудыг биелүүлэх шаардлага тавьдаг.

2.4 MNS Хариуцлагатай малчин- зохистой дадал

Малын гаралтай түүхий эд мөшгөх тогтолцоог хэрэгжүүлснээр түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах, нийлүүлэлтийн сүлжээг бүхлээр нь мэдэхийн сацуу малчин өрх, бэлчээр ашиглагчдын холбоо (БАХ)-ны гишүүдэд зах зээлд нэвтрэх боломжийг олгох юм. Үүний хүрээнд, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо (МБАНХ) нь 2017 оноос хойш Ус цаг уур, орчны шинжилгээний газар (УЦУОШГ), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ), Монголын ноос, ноолуурын холбоо (МННХ), Монголын арьс ширний холбоотой хамтран “Хариуцлагатай нүүдэлчин” мөшгөх системийг хөгжүүлсэн байна.

Мөшгөх тогтолцоо гэж малын гаралтай түүхий эдийг малчны хотноос эхлээд эцсийн хэрэглэгчийн гар дээр тавих хүртэлх алхам бүрийг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн хянах үйл явц юм.

Зураг 10. Хариуцлагатай нүүдэлчин мөшгих тогтолцооны хүрээ



Эх сурвалж 5. Ногоон алт төсөл. <https://www.greenmongolia.mn/мөшгөх-тогтолцоо>

Хариуцлагатай нүүдэлчид систем нь УЦУОШГ, ГЗБГЗЗГ-ын бэлчээрийн бүртгэлийн систем, малын бүртгэлийн систем, МЭЕГ-ын мал эмнэлэг, сүлжээ лабораторийн систем, мал эмнэлгийн гэрчилгээний систем зэрэг улсын хэмжээний мэдээллийн сантай холбогдсон ажээ.

Зураг 11. Хариуцлагатай Нүүдэлчид системийн шалгуур үзүүлэлтүүд

Түүхий эдийн чанарыг хэрхэн хянах вэ?	Хариуцлагатай малчид хэрхэн нотлох вэ?	Байгаль орчинд ээлтэй байдлыг хэрхэн нотлох вэ?
<p>ЧАНАРТАЙ ТҮҮХИЙ ЭД:</p> <p>Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн стандартад нийцүүлэн чанарын зэрэглэлээр авч үзнэ. Жишээ нь: Хоршоо нь малчдаас сарлагийн хөөврийг нас, өнгөөр ангилан ялгаж авах бөгөөд 1 настай сарлагийн бүх өнгийн хөөвөр, 2 наснаас дээш сарлагийн цайвар өнгийн хөөврийг дээд зэргийн чанартай түүхий эд гэж үзнэ</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хоршооны бэлтгэж буй түүхий эд тус бүрийн худалдан авалтын бүртгэлийн мэдээлэл <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • “Хариуцлагатай Нүүдэлчид” малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх систем 	<p>ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИД:</p> <p>АБАХ, СБАХ, БАХ-ийн бүртгэл, Бэлчээр ашиглалтын гэрээний бүртгэл, Хоршооны бүртгэл, Түүхий эд худалдан авалт, зарцуулалтын бүртгэл</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд :</p> <ol style="list-style-type: none"> 1. БАХ-ийн гишүүн 2. Гэрээ байгуулсан 3. Гэрээний хэрэгжилт 4. Хоршооны гишүүн 5. Түүхий эд тогтмол нийлүүлдэг <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын ГАЗРЫН БҮРТГЭЛ мэдээллийн сан • “Хариуцлагатай Нүүдэлчид” малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх систем 	<p>БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙДАЛ:</p> <p>Сонгосон бэлчээрийн экосистем дэх биологийн олон янз байдал, амьдрах орчны чанарыг зонхилох зүйл ургамлын бүрхэцийн хувиар илэрхийлнэ.</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Унаган ургамлын эзлэх хувь тухайн жилийн түвшин лавлагаа түвшний 60-аас доошгүй хувьтай тэнцүү 2. Унаган ургамлын эзлэх хувь суурь түвшинтэй тэнцүү буюу илүү <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын ГАЗРЫН БҮРТГЭЛ мэдээллийн сан • “Хариуцлагатай Нүүдэлчид” малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх систем

Бэлчээрийн эрүүл байдлыг хэрхэн хянах вэ?	Малын эрүүл байдлыг хэрхэн хянах вэ?	Малын тавлаг байдлыг хэрхэн хянах вэ?
<p>БЭЛЧЭЭРИЙН ЭРҮҮЛ БАЙДАЛ:</p> <p>Фотомониторингийн цэгийн тухайн жилийн төлөв байдлын үзүүлэлтийг суурь /2018/ онтой харьцуулж үнэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зөв ашиглалттай соргог бэлчээр ✓ Зохистой ашиглалтыг нэвтрүүлснээр сайжирч буй бэлчээр ✓ Бэлчээр хүчтэй доройтож байгаа тул ашиглалтын горим, ачааллыг өөрчлөх шаардлагатай <p>Шалгуур үзүүлэлтүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ургац (кг/га) 2. Бэлчээрийн доройтол болон сэргэх чадавхийн түвшин <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын ГАЗРЫН БҮРТГЭЛ мэдээллийн сан • “Хариуцлагатай Нүүдэлчид” малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх систем 	<p>МАЛЫН ЭРҮҮЛ БАЙДАЛ:</p> <p>МЭЭГазрын системээс Халдварт өвчнөгий, тайван байдал, халдварт болон шимэгчтэх өвчний дархлаажуулалт, мал эмнэлгийн байгууллагатай байгуулсан гэрээ, эмийн үлдэгдэлийн шинжилгээ, мал эмнэлгийн гэрчилгээ Малчны А дансны бүртгэл</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд :</p> <ol style="list-style-type: none"> 1. Мал эмнэлгийн үйлчилгээний мэдээлэл 2. Мал эмнэлгийн цахим гэрчилгээ 3. Малчны А дансны бүртгэл <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • ХХААХҮЯ, Мал Эмнэлгийн Ерөнхий Газар, Малын эрүүл мэндийн нэгдсэн систем • УМЭАЦТЛаборатори, Мал эмнэлгийн лабораторийн удирдлага мэдээллийн систем 	<p>МАЛЫН ТАВЛАГ БАЙДАЛ:</p> <p>Малын өвлийн хашаа/байртай, хүрэлцэхүйц өвс, тэжээл, усан хангамж бэлтгэсэн.</p> <p>Шалгуур үзүүлэлтүүд :</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Зүй бус хорогдол:</u> 2. <u>Өвлийн хашаа, саравчны хүрэлцээ хангамж:</u> 3. <u>Бэлтгэсэн өвс тэжээлийн хэмжээ:</u> 4. <u>Усан хангамжийн хүрэлцээ:</u> <p>НОТЛОХ ЭХ ҮҮСВЭР:</p> <p>ХХААХҮЯ, Мал аж ахуйн систем</p> <ul style="list-style-type: none"> • “Хариуцлагатай Нүүдэлчид” малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх систем

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадал MNS 6891:2020⁷ стандарт нь Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл, усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржүүлэг селекц, тэжээллэг, арчилгаа, маллагаа зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлыг нэвтрүүлэхэд хамаарна. Энэ стандартыг тогтвортой, хариуцлагатай Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний байгууллагуудад хамаарна. Үүнд, орон нутгийн малчид, малчдын байгууллага нь /СБАХ, БАХ, Хоршоо/

- Бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх (20 үзүүлэлт),
- Малын чанар (10),
- Эрүүл мэнд, үүлдэр угсааг сайжруулах (5),
- Малын тавлаг байдал (20),
- Хариуцлагатай (20- БАХ-ын гишүүн, Хоршооны гишүүн, Бэлчээр ашиглах гэрээ, Хоршоонд түүхий эд нийлүүлэлт)
- Байгаль орчинд ээлтэй (20)

гэх мэт үзүүлэлтүүд дээр анхаарч, үйлдвэрийн хаалга хүртэл байгальд ээлтэй аргаар зөв бэлтгэх бүхий л үйл ажиллагааг хамааруулна.

Одоогийн байдлаар уг системд нийт 18 аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, 156 сумын БАХ, 1445 БАХ-ийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Мөн 82 түүхий эдийн анхан шатны

⁷ <https://standard.gov.mn/standard/v/6714>

хоршоо, 6 дундын хоршоо, 20 хадгаламж зээлийн хоршоодын мэдээлэл бүртгэгдсэн байна (Ногоон алт төсөл⁸).

2.5 Текстилийн салбарт баримтлах ТоС-ийн удирдамж

Монголын Улсын текстилийн салбарын байгаль орчин, нийгэм (БОН)-ийн эрсдэлд үндэслэн гаргасан гол БОН-ийн эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна. (ТоС Холбоо, 2019⁹)

Өндөр эрсэлтэй үйл ажиллагаа: Үүнд БОН-д их хэмжээний, олон төрлийн, үл сэргээгдэх сөрөг нөлөөлөл, эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагааг хамруулна.

- Бэлчээрийн муу менежмент болон бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотойгоор малын тоо толгой ихэссэн.
- Хаягдал ус цэвэршүүлэх систем муу/байхгүйгээс үүдэлтэйгээр байгаль орчны бохирдол, хөрсний болон гадаргын усны бохирдол нэмэгдэж, хүн болон амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бий болж байна.

Дунд зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа: Байгаль орчин, нийгэмд орон нутгийн шинж чанартай, бага хэмжээний, нөхөн сэргээгдэх боломжтой эрсдэл / сөрөг нөлөөлөл учруулах үйл ажиллагаа багтана.

- Эрчим хүчний ул мөрийн үнэлгээ, аргачлал муу байгаатай холбоотойгоор шаардлагагүй эсвэл хэмнэгдэж болох эрчим хүчний зардал гардаг.
- Усны хэрэглээ (газрын гүний усны шууд ашиглалт)-ний хяналт, менежмент хийдэггүй байдал нь усны нөөц багасахад хүргэж болно.
- Санхүү, хүний нөөц дутмаг шалтгаанаар ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал сайн хангагддаггүй.

Тогтвортой санхүүгийн удирдамж ба Дью Дилижинс

Харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой БОН-ийн эрсдэлийг цогцоор үнэлэхдээ банк одоо хэрэглэгдэж буй олон улсын аргачлалуудыг хэрэглэж болно. ТоС-ийн зарчмууд нь Монголын нэхмэлийн салбарын үйлдвэрүүдийн БОН-ийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг тодорхойлох гол зарчим байна.

ТоС-ийн 8 зарчим

Зарчим 1: Байгаль орчныг хамгаалах

Зарчим 2: Хүний эрх, нийгмийг хамгаалах

Зарчим 3: Соёлын өвийг хамгаалах

⁸ <https://www.greenmongolia.mn/мөшрөх-тогтолцоо>

⁹ Нэхмэлийн салбарын ТоС удирдамж <http://www.toc.mn/post/111>

Зарчим 4: Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

Зарчим 5: Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Зарчим 7: Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Зарчим 8: Манлайлан үлгэрлэх


Мал аж ахуйд хүүхдийн хөдөлмөр буюу оруулах хувь нэмэр нь урт хугацаанд хэрэгжиж буй түүхэн, нүүдлийн соёлын хэсэг билээ. Тиймээс хүүхдийн болон жендертэй холбоотой эрсдэлүүдээс сэргийлэхийн тулд энэ асуудлыг сайтар хянаж, зохицуулах хэрэгтэй. “Малтай ажиллахад үүсэх аюул болон хөдөө орон нутагт амьдарч буй хүүхдэд учирдаг аюулуудыг хооронд нь ялгах хэрэгтэй”.¹⁰ Иймээс аргачлалыг нь тодорхойлохын тулд хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгааг маш тодорхой зорилгын хүрээнд хийх шаардлагатай.

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын систем (БОНЭУС) нь дараах 4 гол зүйлсээс бүрдэнэ.

- Байгаль орчин, нийгмийн бодлого
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ ба дью дилиженс
- БОНУС-ын үйл ажиллагаа ба хэрэгжүүлэлт
- Үргэлжилсэн мониторинг ба тайлагнал

¹⁰ Children’s work in the livestock sector: Herding and beyond, FAO, 2013

Зураг 12. БОНУС-ийн бүрдэл



Тогтвортой санхүүжилтийн нэг үндсэн бүрэлдэхүүн нь байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлийн удирдлага байдаг. Монгол Улсын бүх арилжааны банкууд 50 сая төгрөгөөс дээш, 12 сараас дээш хугацаатай бүх төрлийн бизнесийн зээлд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг хийж байна.

2.6 Текстилийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлал

Тэгвэл текстилийн салбарын БОНЗ-ын эрсдэлийг үнэлэхдээ ТоС Холбооноос боловсруулсан текстилийн салбарын тусгайлсан БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний

Зураг 13. Текстилийн БОНЗ-ын аргачлалын процессын зураглал



аргачлалыг ашиглаж, текстилийн салбарт хамааралтай гол БОНЗ-ын эрсдэлүүдийг тусгайлан үнэлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авна (Зураг 12).


Уг БОНЗ-ын үнэлгээ нь харилцагчийн болон төслийн гэсэн үндсэн хоёр ангилалд үнэлгээг хийх ба төслийн хувьд илүү нарийвчилсан, салбарын онцлогийг тусгасан байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээг өгөгдсөн асуултуудад “тийм”, “үгүй” гэсэн хариулт өгөх замаар хялбараар хийж гүйцэтгэдэг. Үнэлгээний төгсгөлд тухайн харилцагчийн болон төслийн БОНЗ-ын эрсдэлийн түвшин (бага, дунд, өндөр) автоматаар тооцоологдоно.

БОНЗ-ын үнэлгээний хамгийн эхний алхам бол харилцагч эсвэл төслийн үйл ажиллагааны чиглэл дараах жагсаалтад багтсан эсэхийг шалгах явдал юм.

1. Хориотой үйл ажиллагааны жагсаал ¹¹ буюу санхүүжүүлэхээс татгалзах үйл ажиллагааны жагсаалт
2. Анхаарах үйл ажиллагааны жагсаалт

¹¹ <http://toc.mn/post/26>

Зураг 14. Текстилийн БОНЗ-ын эрсдэлийн аргачлалын шалгуур



Эх сурвалж 6. ToC Холбоо, STeP EcoLab төсөл (2020)

Дээрх үнэлгээний дагуу тухайн зээл авах хүсэлтэй төсөл, харилцагч нь БОНЗ-ын дунд болон өндөр эрсдэлтэй гэж үзвэл зээл олгох шийдвэрийн хүрээнд БОНЗ-ын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөөг санхүүжүүлэгч байгууллагаас, харилцагчтай зөвшилцөх замаар тодорхойлж, зээлийн хорооны тэмдэглэл эсвэл зээлийн гэрээнд тусгана (Зураг 13). Эсвэл банк, санхүүгийн байгууллага нь БОНЗ-ын өндөр эрсдэлтэй харилцагч эсвэл төслийг санхүүжүүлэхээс татгалзах хүртэл арга хэмжээ авч болно. Уг тодорхойлсон арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг зээлийн эргэн төлөлтийн хамт хянаж, хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах, зээл олголтыг зогсоох, хүртэл арга хэмжээг зарим санхүүжүүлэгч байгууллагууд авдаг.

МОДУЛЬ 2. Багийн хэлэлцүүлэг, дасгал ажил #3

Сэдэв: Текстилийн салбарын харилцагчийн байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх, эрсдэл бууруулах арга хэмжээг тодорхойлох

Нийт хугацаа

30 мин (20 мин багийн хэлэлцүүлэг, 10 мин үр дүн танилцуулах)

ЗААВАР:

- Өгөгдсөн жишээ кейсийн мэдээлэлд үндэслэн харилцагчийн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлийг тодорхойлох, эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах. Ингэхдээ дараах зүйлс дээр хариултыг бэлтгэнэ үү.
 - Харилцагчийн БОНЗ-ын эрсдэлийг үнэлэхэд өгөгдсөн мэдээлэл хангалттай байна уу? Хангалтгүй гэж үзсэн бол ямар нэмэлт мэдээлэл шаардлагатай байна вэ? *(Cheat note: БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний тайлбар хэсгээс зайлшгүй анхаарч үзэх асуултууд, тогтвортой үйлдвэрлэлтэй холбоотой асуултуудыг хэрхэн тэмдэглэсэнг уншиж болно)*
 - Өгөгдсөн мэдээлэлд үндэслэн харилцагчийн БОНЗ-ын эрсдэлийг бага, дунд, өндөр аль нь болохыг багаараа хэлэлцэн тодорхойлно уу. *(Cheat note: БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлалын F баганад ногоон өнгөөр харагдах хариултууд нь эерэг хариултууд болохыг харгалзан үзээрэй)*
 - Харилцагчийн БОНЗ-ын эрсдэл дунд эсвэл өндөр гэсэн дүгнэлтэд хүрсэн бол эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг багаараа ярилцаж гаргана уу. *(Cheat note: БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний L багана дахь мэдээллийг ашиглах боломжтой)*
- Танилцуулга хийх хүнийг томилох
- Танилцуулгыг 2-3 минутад багтаан хийх

Баг 1, 4 - Байгаль орчны эрсдэл

Баг 2, 5 - Нийгмийн эрсдэл

Баг 3, 6 - Засаглалын эрсдэл

КЕЙС:

- “Ноос ноолуур” ХХК цогцолбор үйлдвэр нь 2000 оноос эхлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй бөгөөд үйлдвэрийн шинээр барих барилгын өргөтгөлийн төсөлдөө банкнаас 2 тэрбум төгрөгийн зээл хүсэн ханджээ. Банкны харилцааны менежер уг үйлдвэр зээл судлуулах боломжтой эсэхийг тодорхойлох зорилгоор анхан шатны зээлийн судалгаа хийж, нэг удаагийн аман ярилцлага хийсний үр дүнд дараах мэдээллүүдийг олж авчээ.

- Үйлдвэрийн талаар интернэтээс судалж үзэхэд үйлдвэрийн удирдлагууд 2 жилийн өмнө авлигын хэрэгт холбогдож, цагдаагийн байгууллагаас хэд хэдэн удаагийн хяналт шалгалт хийгдсэн талаар мэдээлэл, шүүхийн тамга тэмдэг бүхий хуудсууд олон нийтийн сүлжээнд тавигджээ.
- Үйлдвэр нь гэр бүлийн бизнес бөгөөд үйлдвэрийн ТУЗ-ын даргын эхнэр үйлдвэрийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэдэг, түүний том хүү үйлдвэрийн санхүү эрхэлсэн захирлын албыг хашдаг байна.
- Үйлдвэрийн эзэнтэй ярилцлага хийж байх явцад тэрээр эмэгтэйчүүдийг ажилд авах дургүй, хүүхэд төрүүлэх өсгөх гээд ажил хойш татдаг, орны хүнийг нь хайх гэж ажил уддаг хэмээн төвөгшөөн ярьж байв.
- Үйлдвэрийн НДШ-ийн тайланг авч үзэхэд ижил албан тушаалтай эрэгтэй, эмэгтэй ажилтнууд ялгаатай цалин авдаг нь харагдав.
- Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг харахад 5 гишүүний 2 нь үйлдвэрийн эзний төрсөн ах, дүү хоёр болох нь тогтоогдлоо.
- Үйлдвэр 56 ажилтантай бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлтэй.
- Уг үйлдвэрт ХАБЭА-н сургалт зохион байгуулсан, аюулгүй байдлын зааварчилгааг холбогдох ажилтнуудад өгсөн тэмдэглэл, бүртгэл байхгүй байна.
- Үйлдвэрийн барилгыг 1999 онд барьж ашиглалтад оруулсан бөгөөд түүнээс хойш барилгын хийц, сантехник муудсан. Барилга дулаан алдагдал ихтэйгээс шалтгаалан үйлдвэр цахилгаан, дулааны төлбөрт сард 3 сая орчим төгрөг төлдөг.
- Уг үйлдвэр МУ-ын эрчим хүч хэмнэлтийн хуулийн дагуу Үүрэг хүлээсэн хэрэглэгчээр нэрлэгдсэн бөгөөд жил бүр тодорхой хэмжээгээр эрчим хүчний хэмнэлт гаргах үүргийг хуулиар хүлээсэн. Үйлдвэр цахилгааны төлбөрийн хэмжээг бууруулахын тулд оффисын давхруудад LED гэрэлтүүлэг суурилуулжээ.
- Үйлдвэр 4 сүлжмэлийн машинтай бөгөөд эдгээр нь Хятад улсаас авсан өмнө хэрэглэж байсан машинууд юм. Үйлдвэрийн эзэн ярилцлагын явцад эдгээр нь тог их иддэг, орчин үеийн эрчим хүчний хэмнэлттэй машинуудаар солих хүсэлтэй талаар дурдаж байв.
- Үйлдвэр халуун ус, уурыг дахин ашигладаг.
- Үйлдвэр Туул голтой ойр байршдаг бөгөөд лаг зайлуулалтын бүртгэл хөтөлсөн тэмдэглэл байхгүй байна.
- Үйлдвэр сүлжмэл бүтээгдэхүүнийг өнгөнд оруулахдаа хлор суурьт цайруулагч ашигладаг, харин принтинг хийхдээ фталат, PVC ашигладаг.
- Үйлдвэрт химийн болон туслах материалыг хадгалах зориулалтын агуулахтай.
- Үйлдвэрлэлээс бий болсон хаягдал усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.

МОДУЛЬ 3.

ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН НОГООН ТӨСӨЛ, ЗЭЭЛ

Товч танилцуулга

Энэхүү модуль нь текстилийн салбарын тогтвортой ногоон санхүүжилтийн эрэлт, нийлүүлэлт, боломжит санхүүгийн эх үүсвэрийг тоймлосон. Тэр дундаа STeP EcoLab төслийн хүрээнд текстилийн салбарт тусгайлан боловсруулсан ногоон зээл олгох шалгуур, аргачлалыг танилцуулав. Аргачлалын дагуу текстилийн ногоон зээлд хамрагдах боломжтой төслүүдийн төрөл, шалгуур үзүүлэлтүүдийг тоймлосон бөгөөд уг аргачлалыг банк, санхүүгийн байгууллага сайн дураар авч хэрэгжүүлэх боломжтой юм.

Цаашлаад энэ модульд ногоон зээлийн шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн баталгаажуулах гэрчилгээ, шошго, үйлдвэрлэгчдийн талаар танилцуулна.

Онцлох сэдвүүд:


- Текстилийн салбарын ногоон санхүүжилт, ногоон төслийн өнөөгийн байдал бэрхшээл
- Текстилийн салбарт олгон ногоон зээл олгох шалгуур, аргачлал
- Баталгаажуулалтын арга: Италийн текстилийн машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбоо (ACIMIT, RINA)-ны ногоон шошго
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн жишээ



3.1 Текстилийн салбарын ногоон санхүүжилт

Ногоон санхүүжилт, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хөрөнгө оруулалтын чадавхыг тодорхойлох зорилгоор STeP EcoLab төслийн хүрээнд текстилийн салбарын ногоон санхүүжилтийн эрэлтийн судалгааг¹² 2019 онд хийж гүйцэтгэсэн. Нийт текстилийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр 250 тэрбум төгрөг, зорилтот¹³ төсөөллөөр 576 тэрбумд хүрэх боломжтой гэсэн тооцоолол гарчээ (Зураг 2) (ТоС Холбоо & Гэрэгэ Партнерс, 2019).

Зураг 15. Текстилийн салбарын ногоон санхүүгийн эрэлт



Эх сурвалж 7. ТоС Холбоо & Гэрэгэ Партнерс. 2019. Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа, STeP EcoLab төсөл.

Судалгаанд оролцсон үйлдвэрүүдийн эрэлтийг зориулалтаар ангилбал,


- 62% нь үйлдвэрийн барилга, байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах болон цахилгаан, эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи нэвтрүүлэхэд,
- 20% нь бохир ус цэвэрлэх байгууламж барих зориулалтаар ногоон санхүүжилт авах хүсэлтэй гэжээ.

Гэтэл нийлүүлэлт талаас үзвэл, текстилийн үйлдвэрүүдийн хандах боломжтой ногоон санхүүжилтийн нийт боломжит эх үүсвэр нь 75 тэрбум төгрөг байна. Иймд эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхийн тулд текстилийн салбарын ногоон эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

¹² ТоС Холбоо & Гэрэгэ Партнерс. 2019. Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа, STeP EcoLab төсөл.

¹³ Ноолуур төслийн зорилтуудыг тусгасан.

Зураг 16. Ногоон санхүүжилтийн эх үүсвэр



Зөрүүг арилгахын тулд, нэг талаас санхүүгийн байгууллагууд:

- ◆ Ногоон санхүүжилтийн эх үүсвэр бий болгох
- ◆ Текстилийн салбарын онцлогийг тусгасан ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх
- ◆ Текстилийн салбарын харилцагчийн төсөлд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ хийх чадавх бүрдүүлэх
- ◆ Текстилийн салбарын харилцагчийн төсөл ногоон мөн эсэхийг үнэлэх чадавх бүрдүүлэх

Нөгөө талаас текстилийн үйлдвэрүүд:

- ◆ Үйл ажиллагаагаа тогтвортой, байгальд ээлтэй явуулахыг зорих
- ◆ Үйлдвэрийн БОНЗ-ын эрсдэлийг бууруулах
- ◆ Банкны ногоон зээлийн шаардлагыг хангахуйц төсөл боловсруулах шаардлагатай байна.

3.2 Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлал

Зорилго: Ногоон зээл олгох аргачлал¹⁴ нь аливаа санхүүгийн байгууллага Монгол Улсын текстилийн салбарын ногоон төсөлд санхүүжилт олгох, төслийг үнэлэхэд ашиглах суурь шалгуур, ангиллыг тодорхойлсон баримт бичиг юм.

Ногоон зээл олгох шалгуур, аргачлалыг тодорхойлсноор санхүүгийн байгууллага төдийгүй төсөл санаачлагч, хэрэгжүүлэгч байгууллагууд нэгдсэн ойлголттой болж, ногоон төслийг санхүүжүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, ногоон нөлөөллийг хэмжих, баталгаажуулах, тайлагнах явц илүү тодорхой болгох юм. ТоС Холбооноос боловсруулсан ногоон зээлийн шалгуурыг Монгол Улсын текстилийн үйлдвэрлэлд тусгайлан тохируулж боловсруулсан бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд текстилийн салбарын ногоон зээлийг судлах, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлийг хянах, бууруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар өөрийн банкны ТоС-ийн үйл ажиллагааг сайжруулах, улмаар Монгол Улсын тогтвортой үйлдвэрлэл, ногоон хөгжилд хувь нэмэр оруулах өндөр ач холбогдолтой юм.

Олон улсад ногоон зээл олгохдоо ил тод байх, ногоон ухуулгаас (green washing) холуур байх зарчмын хүрээнд ногоон зээл олгохыг зөвлөдөг. Тухайлбал Зээлийн зах зээлийн Холбоо (Loan Market Association)¹⁵-оос боловсруулсан “Ногоон зээлийн зарчмууд” гэсэн баримт бичигт ногоон зээл олгоход баримтлах үндсэн зарчмуудыг тайлбарласан бөгөөд уг зарчим нь ногоон зээлийн зориулалт, нөлөөлөл болон үнэлгээ, зээлийн дараах хяналт болон тайлагнал гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлалын үе шат

Энэхүү текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлалыг боловсруулахдаа олон улсын зарчмууд, ТоС-ийн зарчмууд, Монгол Улсын Ногоон таксономийг удиртгал болгосон. Санхүүжүүлэгч байгууллага нь текстилийн салбарын ногоон зээлийг санхүүжүүлэх эсэх шийдвэр гаргахдаа доорх зээлийн зураглалын дагуу харилцагч эсвэл төслийг үнэлэх бөгөөд ногоон болон техникийн шалгуурыг зээлийн анхан шатны үнэлгээ (screening) болон зээлийн нарийвчилсан судалгаа хийхэд ашиглана. Зээлийн хүсэлтийг хүлээн авсны дараа анхан шатны ярилцлага хийж, банкны өргөдлийн маягтыг бөглүүлж ногоон зээлийн шалгуурыг ашиглан тухайн төслийг ногоон зээлээр санхүүжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлно.

¹⁴ <http://www.toc.mn/post/125>

¹⁵ Ази Номхон далайн орнуудын зээлийн зах зээлийн холбоо (Asia Pacific Loan Market), Зээлийн синдикатууд ба худалдааны холбоо (Loan Syndications & Trading Association) хамтран боловсруулсан.

<p>Усны хэрэглээ</p>	<ul style="list-style-type: none"> Цэвэр усны хэмнэлттэй машин, тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах Бохир ус цэвэрлэх машин, тоног төхөөрөмж худалдан авах
<p>Химийн бодис зохистой хэрэглээ</p>	<ul style="list-style-type: none"> Ногоон шаардлага хангасан химийн бодис худалдан авах Химийн бодисын агуулах, лаборатори, станц барих
<p>Хог хаягдлын менежмент</p>	<ul style="list-style-type: none"> Хатуу хог хаягдлыг дахин ашиглах, дахивар болгох, сав суулга худалдан авах Дахин боловсруулсан эсвэл байгальд хоргүй материалаар хийгдсэн уут, сав, баглаа боодол, хайрцаг худалдан авах
<p>ЭХХ, ногоон барилга</p>	<ul style="list-style-type: none"> ЭХХ-тэй барилга барих Ногоон барилга барих
<p>Карбон бага буюу цэвэр тээвэр</p>	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрийн хэрэгцээний тээврийн хэрэгслийг цахилгаан, хайбрид машин болгох

Ногоон эргэлтийн хөрөнгийн зээл нь үйлдвэрүүд тогтвортой аргаар бэлтгэсэн түүхий эд худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай байна. Тухайлбал:

Хүснэгт 2. Текстилийн үйлдвэрийн ногоон эргэлтийн хөрөнгийн зээл, ерөнхий зориулалтаар

Ангилал	Ерөнхий ногоон зориулалт
<p>Тогтвортой аргаар түүхий эдийн бэлтгэх</p>	<ul style="list-style-type: none"> Тогтвортой аргаар бэлтгэсэн, чанарын гэрчилгээтэй түүхий эдийг худалдан авах Бүтээгдэхүүн, түүхий эдийн мөшгөх системийг бий болгох, хөгжүүлэх

А. Суурь үзүүлэлтийг тодорхойлох

Ногоон зээлийн зарчмын дагуу төсөлд ногоон санхүүжилт олгохоос өмнөх суурь үзүүлэлт (baseline) ба ногоон зээл олгосны дараа бий болох үр дүнг тоон ба чанарын үзүүлэлтээр тооцсоноор ногоон зээл олголтын нөлөөллийг хэмжих, баталгаажуулах, тайлагнах нөхцөл бүрдэх билээ. Суурь үзүүлэлтийг тодорхойлохдоо холбогдох зохицуулагч байгууллагаас тодорхойлсон үзүүлэлт, олон нийтэд нээлттэй салбарын судалгаа, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, МУ-ын ноос ноолуурын салбарын тогтвортой байдлын үндэсний стандартууд, тухайн харилцагчийн өмнөх 1-3 жилийн үзүүлэлт (эрчим хүчний хэрэглээ, усны хэрэглээ, үйлдвэрийн хаягдал усны хэмжээ ба хоруу чанар гэх мэт), хөндлөнгийн үнэлгээ, аудитын дүгнэлт зэрэг мэдээлэлд суурилан тодорхойлж болно.

В. Ногоон шалгууруудыг хангаж буй эсэхийг баталгаажуулах

Текстилийн салбарын ногоон төслүүдэд зээл олгохоос өмнө тухайн төсөл, зээлийн зориулалт нь доорх техникийн шалгууруудыг хангаж буй эсэхийг үнэлж баталгаажуулна. Баталгаажуулалтыг хийхдээ доорх эх сурвалж, баримт бичгүүдийг ашиглаж болно.

- Зээлээр авахаар төлөвлөж буй тоног төхөөрөмж, түүхий эд, барилга байгууламжийн ногоон/тогтвортой шошго, гэрчилгээ, стандарт
- Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, гэрчилгээ
- ЕСБХБ-ны Ногоон технологийн каталог
- Хөндлөнгийн аудиторын үнэлгээ, дүгнэлт/шинжилгээ
- Бусад судалгаа, тооцоолол, баталгаажуулалт.

Ногоон зээлийн ангилал тус бүрээр холбогдох шалгуурыг “Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлал¹⁶” тайлангийн Бүлэг 2. 11-30 дугаар хуудсанд дэлгэрэнгүй тайлбарлав.

С. Ногоон зээлийн хяналт, тайлагнал

Явцын хяналт

Банкны явцын хяналтад дараах гурван төрлийн хяналтыг багтааж болох бөгөөд эргэн хяналтыг хамгийн багадаа жилд нэг удаа хийнэ.

- Зээлдэгчээс холбогдох тоон болон чанарын мэдээлэл, явцын мэдээлэл, тайлан авах
- Банкны эргэн хяналт, газар дээрх хяналт шалгалт (зээлийг зориулалтаар ашиглаж буй эсэх)
- Хөндлөнгийн байгууллагын аудит, үнэлгээ, хяналт, баталгаажуулалт

Банкны эргэн хяналтыг банкны зээлийн хяналт, зээлийн эрсдэл, ногоон зээл хариуцсан газар, нэгжээс хийх нь тохиромжтой. Эргэн хяналтыг хийхдээ зээлийг зээлийн судалгааны явцад тодорхойлсон зориулалтаар ашиглаж буй эсэх, ногоон үр дүнгүүд гарч буй эсэх, зээлийн гэрээ бусад баримт бичигт тусгагдсан шаардлага, төлөвлөгөөг биелүүлж буй эсэхийг шалгах бөгөөд, БОНЗ-ын эрсдэл бууруулах төлөвлөгөө гарсан тохиолдолд төслийн шалгах хуудсыг боловсруулж явцын хяналтад давхар ашиглана.

Нөлөөллийн тайлан

Ногоон зээл олгосон санхүүгийн байгууллага нь жил бүр (хамгийн багадаа) ногоон зээлийн зориулалт тус бүрээр харилцагчаас байгаль орчин, ногоон нөлөөллийн үнэлгээг тоон болон чанарын индикатор, хэрэгжилтийн тайлан хэлбэрээр гаргуулж авна. Өөрөөр хэлбэл ногоон зээл олгосны үр дүнд бууруулсан эрчим хүч, ус, материалын хэрэглээ, бууруулсан/ялгарахаас сэргийлсэн ХХЯ, бохирдлын хэмжээг бүртгэж, нөлөөллийн тайланг гаргана. Жишээ индикаторуудыг “Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлал” тайлангийн Бүлэг 4. 32-33 дугаар хуудсанд танилцуулав.

¹⁶ <http://www.toc.mn/post/125>

Мөн түүнчлэн тухайн ногоон зээлийн зарцуулалт нь олон улсын болон дотоодын ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх болон дасан зохицох чиглэлийн бодлогуудтай хэрхэн уялдаж, хувь нэмэр оруулж буйг тайланд багтаахыг зорино.

Банкны дотоод, гадаад тайлагнал

Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн Зарчим 7 буюу “Ил тод байдал, хариуцлагыг дэмжих” гэсэн зарчмын дагуу санхүүгийн байгууллага нь дээрх нөлөөллийн үнэлгээний үр дүнг дотоод ба гадаад оролцогч талуудад тайлагнана.

- Дотоод тайлагнал: ТУЗ/удирдлагын багийн тайлан, банкны жилийн тайлан, тогтвортой байдлын тайлан г.м
- Гадаад тайлагнал: Монголбанкинд сар бүр илгээдэг ногоон зээлийн тайлан, ТоС Холбоонд улирал бүр илгээдэг ТоС-ийн тайлан, хөрөнгө оруулагч, гадаад хамтын ажиллагаатай байгууллагуудад илгээдэг тайлан г.м

3.3 Баталгаажуулах арга: Ногоон шошго, гэрчилгээ

АСИМИТ Ногоон шошго, RINA тогтвортой технологи төсөл

Текстилийн салбар болон бусад салбарууд дараах хэрэгцээг нэгэн зэрэг хангах шинэлэг технологийг эрэлхийлэх нь улам бүр нэмэгдэж байна.



- Үйлдвэрлэлийн процессд илүү уян хатан байдал
- Үйлдвэрлэлийн өндөр үр ашиг
- Эрчим хүчний хэрэглээ буурч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- Үйлдвэрлэлийн өртөг бага

Италийн текстилийн машин үйлдвэрлэгчид шинэ, шинэлэг ногоон технологийн чиг хандлагыг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


2010 онд АЧИМИТ Италийн текстилийн машин үйлдвэрлэгчдийн холбоо “Тогтвортой технологи” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг төслийн зорилго нь ашиглалтын үе шатанд эрчим хүч, ус, химийн бодисын хэрэглээг багасгах замаар байгаль орчинд үзүүлэх нөлөө багатай, эрчим хүчний хэмнэлттэй процессоор тодорхойлогддог үйлдвэрлэлийн загварыг боловсруулах замаар текстилийн үйлдвэрлэлийн өсөлтийг хангахад оршино.

2012 онд АЧИМИТ нь энэхүү хэрэгслийн баталгаажуулсан хувилбарыг танилцуулсан. Олон улсын гэрчилгээжүүлэх байгууллага RINA¹⁷ нь АЧИМИТ ногоон шошгыг гаргах үйл явц болон түүний хэмжилтийг баталгаажуулсан болно.

¹⁷ www.rina.org

АЧИМИТ ногоон шошго нь үйлдвэрлэгчийн үнэлгээний параметр болгон тодорхойлсон процессыг ашиглан нэхмэлийн машин механизмын эрчим хүч, байгаль орчны гүйцэтгэлийг тодорхойлж, тэдгээрийг амархан танигдахуйц, ойлгомжтой болгоход чиглэсэн баримт бичиг юм.

Зураг 18. АЧИМИТ ногоон шошго



Төсөлд 50 орчим компани нэгджээ.




АЧИМИТ Ногоон шошгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах, тогтвортой технологи нийлүүлэгч компаниудыг илүүг мэдэхийг хүсвэл хаягаар¹⁸ орж үзнэ үү.

¹⁸ www.green-label.it

3.4 Бохир ус цэвэрлэх байгууламжийн жишээ


Ханбогд Кашимер ХХК-ны бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи



Ногоон зээлийн шалгуур хангаж буй байдал:

- Зээлийн бүтээгдэхүүн:
 - Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх микрофлотацийн төхөөрөмж
 - Лавгийн насос
 - Фильтр пресс
 - Элсэн шүүлтүүр
 - Кварцан шүүлтүүр
 - РАМ, РАС доозлох төхөөрөмж
- Ногоон ангилал: Бохир ус цэвэрлэх
- Ногоон зориулалт: Бохир ус цэвэршүүлээд дахин ашиглах
- Баталгаажуулалт: Лавлах
- Санхүүжилт: Үйлдвэртэй гэрээ байгуулж зураг, төсөл, угсралтын ажлыг 300-400 сая төгрөгт багтаан хийж улсын комисст хүлээлгэн өгсөн (2020 он)

Агаа цагаа ХХК-ны бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи



Ногоон зээлийн шалгуур хангаж буй байдал:

- **Зээлийн бүтээгдэхүүн:** Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх микрофлотацийн төхөөрөмж (БКТУС код 8421)
- **Ногоон ангилал:** Бохир ус цэвэрлэх
- **Ногоон зориулалт:** Бохир ус цэвэршүүлэх, дахин ашиглах
- **Баталгаажуулалт:** Лавлах
- **Санхүүжилт:** Үйлдвэртэй гэрээ байгуулж зураг төсөл, угсралтын ажлыг гүйцэтгэсэн, 300-400сая төгрөг

Бохир ус цэвэрлэх онцлох тоног төхөөрөмжүүд

Бохир ус цэвэрлэх тоног төхөөрөмж	Ногоон зээлийн зориулалт	БКТУС код
Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх флотацийн төхөөрөмж	Бохир ус цэвэрлэх	8421
Механик сараалж	Бохир ус цэвэрлэх	84212100

Элс баригч	Бохир ус цэвэрлэх	841990
Анаэроб байгууламж	Бохир ус цэвэрлэх	84199090
Биологийн цэвэрлэх байгууламж	Бохир ус цэвэрлэх	84212190
Мембран биологийн реактор	Бохир ус цэвэрлэх	84212190
Вакум насос	Бохир ус цэвэрлэх	841410
Агааржуулах насос	Бохир ус цэвэрлэх	8410
Өөх тос баригч	Бохир ус цэвэрлэх	841990
Бохирын насос	Бохир ус цэвэрлэх	84137035
Бутлагчтай насос	Бохир ус цэвэрлэх	8413
Лагийн насос	Бохир ус цэвэрлэх	8413
Компрессор	Бохир ус цэвэрлэх	841480
Лаг нягтруулагч	Бохир ус цэвэрлэх	8479

Механик сараалж



Бохир ус элс баригч



Бохир ус цэвэрлэгээний флотацийн төхөөрөмж



Мембран биореактор



Насос/бохирын, лагийн, вакуум

Лаг усгүйжүүлэх filter press



МОДУЛЬ 4.

ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Товч танилцуулга

Энэхүү модулиар өмнөх үзсэн сэдвүүдээ бататгах, бодит туршлага болох үйлдвэрийн танилцуулга, малчны ногоон зээлийн туршлагыг судлах болно.

Өнөөдрийн байдлаар текстилийн салбарт тусгайлсан ногоон санхүүгийн бүтээгдэхүүн байхгүй бөгөөд уг салбарын онцлогийг тусгасан, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн зайлшгүй шаардлагатай байна. Иймд текстилийн салбарын ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дасгал ажил болгон оруулав.

Онцлох сэдвүүд:

- ХасБанк, Ногоон алт малын эрүүл мэндийн төслөөс хэрэгжүүлсэн туршилтын малчны ногоон зээл
- ГОВЬ ХК-ийн тогтвортой үйлдвэрлэлийн туршлага
- Текстилийн салбарын ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дасгал ажил



4.1 Туршилтын малчны ногоон зээл

ХасБанк & Ногоон Алт Малын эрүүл мэнд төслөөс хэрэгжүүлсэн туршилтын ногоон зээл төслийн үр дүнгээс

Мал аж ахуйн салбар Монгол Улсын үндэсний эдийн засгийн тулгуур салбарын нэг билээ. Улсын хэмжээнд нийт 140 мянга гаруй малчин өрх бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байна.

“Ногоон бэлчээр” төслийн зорилго нь тогтвортой бэлчээрийн тогтвортой менежментийг дэмжих, сонгогдсон малчдыг малын тоогоо аажмаар бууруулахад дэмжлэг үзүүлэх, ногоон зээл олгох малчдад бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, малын тооны бууралтын шалгуурыг сонгох, малчид, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага бий болгох, төслийг удирдлага, хэрэгжүүлэлт, мониторинг, үнэлгээг хийх, төслийн цаашдын хэрхэн өргөжүүлэх хэрэгжүүлэх талаар санал боловсруулах, цахим эргэн мөшгөх системийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, тогтвортой бизнесийн загварыг хөгжүүлэх, малчид, малчдын байгууллагад хөнгөлөлттэй ногоон зээлийн шалгуурыг боловсруулахад чиглэгдсэн. Төслийн танилцуулга бичлэгийг эндээс үзнэ үү¹⁹.

Төсөлд нийт 97 малчин айл өрх хамрагдсан бөгөөд холбогдох мэдээллүүдийг доорх хүснэгтүүдээс харна уу.

Хамрагдсан малчин өрхүүд

Малын тоо	Өрхийн тоо	Гэр бүлийн гишүүд	Эзлэх хувийн жин	Малын тоо	Эзлэх хувийн жин	Авсан зээлийн хэмжээ	Эзлэх хувийн жин
901-1500	6	36	6%	6920	14%	52 500 000	11%
801-900	1	5	1%	888	2%	6 000 000	1%
601-800	19	109	20%	13318	27%	104 000 000	21%
401-600	34	177	35%	16444	34%	175 500 000	35%
301-400	20	87	21%	6481	14%	85 500 000	17%
100-300	17	71	18%	4283	9%	76 500 000	15%

Зээлийн зориулалт

¹⁹ <https://www.youtube.com/watch?v=5OvQJPxVTws&t=748s>

N	Зээлийн зориулалт	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Эрүүл мэндийн төвүүдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн нийт дүнгийн хувь
1	Өвс хадлан тэжээл бэлтгэх, хадлангийн талбай хашиж сайжруулах	106,833,500	20.8
2	Малын хашаа саравчаа сайжруулах	37,345,000	7.3
3	Худаг засварлах	2,500,000	0.5
4	Сайн үүлдрийн мал худалдах авах	96,085,000	18.7
5	Шинэ бэлчээрт гарах уулын зам засах	2,000,000	0.4
6	Малын бус гаралтай орлогын эх үүсвэртэй болох	2,225,000	0.4
7	Хүүхдүүдийн сургуулийн төлбөр	8,880,000	1.7
8	Ахуйн хэрэгцээний бараа материал хоол хүнс авах	14,880,000	2.9
9	ХААН Банкны 2 хувийн хүүтэй зээл төлөх	243,800,000	47.4
10	Нийт дүн		100%

Төслийн хүрээнд мөшгөх системийг ашиглах болсонтой холбогдуулан малчин айл өрхийн малыг ээмэгжүүлэлтэнд хамруулж, шаардлагатайтоног төхөөрөмжийг авсан.

Малын эрүүл мэнд гарал үүслийн мөшгөх систем нэвтрүүлэх, малын тоог бэлчээрийн даацад тохируулах ажил.

1. Тоног төхөөрөмж нийлүүлэх

№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Сумдын малын эмч нарт яаралтай оношлох иж бүрдэл	багц	1	732,000	732000
2	Амьтдыг оруулах мотопомп	хэсэг	1	1,280,000	1280000
3	Фито ариутгалын сав	хэсэг	1	310,000	310000
4	Чихний хаяг RFID уншигч	хэсэг	1	1,620,000	1620000

5	Хөдөлгөөнт принтер	хэсэг	1	240,000	240000
6	Чихний таг засах хэрэгсэл	хэсэг	2	15,000	30000
7	RFID чихний шошго	хэсэг	900	2,400	2160000
8	100 ширхэг түргэн туршилт бүхий эмийн үлдэгдэл илрүүлэгч	хэсэг	1	2,400,000	2400000
9	Компьютер	хэсэг	2	1,100,000	2200000
10	Өнгөт принтер	хэсэг	1	386,667	386667
	Нийт дүн			11358667	

Малчин болгон сүргийн эргэлт хийж байх ёстой байдаг. Малчдад сүрэг дотроо сүргийн эргэлт хийх ач холбогдлыг ойлгуулах зорилгын хүрээнд малчдад зориулсан сүргийн эргэлтийн цахим программыг гаргасан. Төсөлд хамрагдсан малчин айл өрх бүрд сүргийн эргэлтийн программыг хийж өгсөн.

2. Сүргийн эргэлтийн цахим программ нэвтрүүлэх

Төсөлд хамрагдсан малчдыг мэдээллийг мал эмнэлгийн эрүүл мэндийн цахим системд бүртгүүлсэн.

3. Малын тоо толгой бууруулах

Цахим гэрчилгээнд бүртгүүлэн зах зээлд гаргасан малын тоо 43.5 хувиар нэмэгдсэн байна. Борлуулсан ямааны тоо өмнөх оноос 53.3 хувиар өсөж борлуулсан хонины тоо 21.0 хувиар нэмэгдэж нийтдээ 2 жилийн турш сумын борлуулсан малын тоо 23.6% хувиар өссөн байна. Төсөлд хамрагдсан нийт малчид хуваарийн дагуу зээлээ төлж дуусгасан байна.

Төслийн үр дүн

Зээл авсан нийт 97 малчин өрх шалгуур үзүүлэлтүүдээ биелүүлсэн. Урт хугацаатай хүү багатай зээл авснаар олон жил хөрөнгө оруулж чадаагүй хөрөнгө оруулалтаа хийж чадсан юм. Ихэнх малчид зээлийг зөвхөн хэрэглээний зориулалтаар авдаг, бэлэн мөнгө дутагдсан үед хөрөнгө оруулалт хийх тухай ойлголт маш бага байсан учир нэмэлт сургалтад хамрагдуулсан. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, Ногоон Алт Төсөл Чандмана суманд 5 жил ажиллаж байна. Бэлчээрийн доройтол нь тогтож, төлөв байдал жигд сайжирч байгаа сум хэдий ч хаврын бэлчээрийн нөөц багатай учраас 35 хүртэлх хувь нь хүчтэй доройтсон төлөв байдалтай байгаа бөгөөд нөхөн сэргэхэд хамгийн багадаа 10 жил шаардагдана. Малын эрүүл мэндийн цахим мөшгөх систем, цахим гэрчилгээний систем амжилттай хэрэгжиж байгаа юм. Малын гаралтай түүхий эдийн мөшгөх цахим

системээр дамжуулан хяналт хийсэн учраас зардал багатай, хурдан хугацаанд мэдээлэл авах боломжтой болсон.

4.2 ГОВЬ ХК-ийн тогтвортой үйлдвэрлэлийн туршлага

Говь ХК нь байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийн ханган Байгаль орчин аялал жуулчлалын яаманд тайланг хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилладаг. Дараа оны менежментийн төлөвлөгөөний БОАЖЯ-аар батлуулан Нийслэлийн байгаль орчны газраас хяналт тавьж ажилладаг.

- **Экологийн нөлөөллийг бууруулахад** чиглэгдсэн үйл ажиллагаанд Газрын тухай хууль 6.5, 6.6-д заасны дагуу Ногоон байгууламжийн талбайг 10%-д хүргэхээр зорин гадаа талбайд зүлэгжүүлэлт, мод тарих зэрэг ажлуудыг тогтмол хийдэг.
- **Биологийн олон янз байдал**, агаарын бохирдол хүлэмжийн хийг бууруулахад чиглэн- Жил бүрийн менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу 2020 онд Богд хан уулын Хийморийн овооны аманд 3 га талбайд 1200 ширхэг шинэс, хуш моддоор ойжуулалтын ажил гүйцэтгэсэн.
- **Химийн бодис**- Химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий ААН байгууллагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд хуулийн дагуу хүлээлгэн өгдөг. Нийслэлийн байгаль орчны газраас химийн бодис устгалтын тусгай дугаартай. Хан-Уул дүүргийн онцгой байдлын газраар Химийн бодисын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажилладаг. /Химийн бодисын тухай хуульд заасан хориглосон химийн бодисыг үйл ажиллагаандаа ашигладаггүй/
- **Хог хаядал** – Хог хаягдлын менежментийн 2019 оноос хойш нэвтрүүлэн байгууллагын хэмжээнд ажилтан бүр хог хаягдлаа ангилан ялгаж хогийн төвлөрсөн цэгээс тээвэрлэх хүртэл ангилан ялгалт хийгддэг. / Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаснаар хог хаягдал, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулахад чиглэж байна./
- **Эрчим хүч** – Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу үүрэг хүлээсэн ААН байгууллагын хүрээнд Эрчим хүчний төлөвлөгөө гарган цаашид эрчим хүчний хэмнэлтийг 5%-д хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Үйлдвэрийн хашаан доторх гэрэлтүүлгийг нарны зайн гэрэлтүүлгээр солихоор 2021онд төлөвлөн ажиллаж байна.
- Технологийн **бохир ус цэвэрлэх байгууламжаа** 243 сая төгрөгөөр шинэчлэн сайжруулж, флотацийн тоног төхөөрөмж суурилуулснаар бохир усыг физик-хими, механик хосолсон технологи ашиглан цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан. Цэвэрлэсэн саарал ус нь Улаанбаатар хотын төвлөрсөн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх усны стандартыг бүрэн хангаж байна.
- **Саарал усыг дахин ашиглах** мембран шүүлтүүрийг суурилуулах, ногоон байгууламжид ашиглахаар 2021 онд төлөвлөн ажиллаж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгч, худалдан авагч нар ОЕКО-ТЕХ стандартын гэрчилгээг шаардах болсонтой холбогдуулан 2020 оны 3 сард Говь ХК өөрийн үйлдвэрлэдэг ээрмэл утас нь дээрээ чанарын гэрчилгээг гардан авсан. Чанарын гэрчилгээ авснаар ОЕКО-ТЕХ-ын хөндлөнгийн баг жил болгон чанарын шалгалт хийж шаардлага хангасан үед

баталгаажуулалтыг сунгадаг. Жишээ нь Говь ХК нь 1800 өнгийн ээрмэл утастай бөгөөд үүнээс төлөөлүүлэн 20 ээрмэл утсыг чанарын шаардлагын шинжилгээнд хамруулж баталгаажуулалт авсан.

Зураг 19. Говь ХК-ийн авсан OEKO-TEX гэрчилгээ



OEKO – TEX стандарт нь ЕХ-ны худалдан авагчдын текстил болон хувцасны хувьд хамгийн их хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээжүүлэлт. Энэ стандартыг Швейцарийн Цюрих хотноо байрлах Текстилийн салбарын экологийг шинжлэх, судлах олон улсын холбооноос олгодог.

OEKO – TEX стандарт нь 1992 оноос эхлэн мөрдөгдөж байгаа стандарт бөгөөд хүний биед хор хөнөөлгүй, химийн хортой бодис агуулаагүй гэдгийг нотлон харуулж байгаа дэлхий нийтийн хэмжээнд мөрддөг нэгдсэн стандарт юм. 2020 оны 3 дугаар сард ГОВЬ ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас OEKO-TEX® 100 стандартын шаардлагыг хангаж чанарын гэрчилгээг гардан авсан.

2021 онд Текстилийн Салбарын Тогтвортой Үйлдвэрлэл Ба Эко Тэмдэг Төсөл /StEP EcoLab/, Монголын Ноос Ноолуурын Холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм”-ийг боловсруулан гаргасан. Говь ХК нь Монголын текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрмийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлэн уг дүрэмд нэгдсэн.

Зураг 20. Монголын Ноос Ноолуурын Холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэмд нэгдсэн батламж



Анхан шатны үйлдвэр 2021 оны 1-р улиралд нь Англи улсад төвтэй “Тогтвортой ноос ноолуурын эвсэл” /ТННЭ - SFA/ байгууллагын “Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал”-ын тохирлын үнэлгээнд хамрагдаж “Мөнгөн батламж” гардан авсан.

Энэ нь ГОВЬ ХК-ийг түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөр аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй байх зэрэг тал дээр тодорхой шалгууруудад нийцүүлэн тогтвортой арга зарчмыг баримтлан үйлдвэрлэл эрхлэн явуулдаг хариуцлагатай компани гэдгийг батлан харуулж байгаа юм.

Зураг 21. Говь ХК-ийн авсан Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлын Мөнгөн батламж



- **НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН АЖЛЫГ ЖИЛ БҮР ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАДАГ**

Говь ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд тогтвортой ноолуур гурван талт хамтарсан төсөл хэрэгжүүлсэн.

- **“ТОГТВОРТОЙ НООЛУУР” ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ**

ГОВЬ ХК Үйлдвэрлэл - Шинжлэх ухаан - Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, улмаар үржлийн шилмэл хээлтүүлэгчийг үржил селекцийн ажилд ашиглах болон малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийг 2020 оноос эхлэн ХААИС-ийн эрдэмтэн багш нар болон малчидтай хамтран хэрэгжүүлж байна.

Малчдын төлөөлөл болгон Баянхонгор аймгийн Жинст сумын Хөнөг баг болон Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Асгат багийн нийт 18 малчин өрхийг сонгон авч хамтран ажиллаж байна.

Төслийн хүрээнд 2020 онд нийт 21 толгой шилмэл омгийн ухныг сайжруулагчаар сонгон авч малчдадаа хүлээлгэн өгсөн. Мөн өвөлжилтийн бэлтгэлд зориулж өвс, тэжээлийн туслалцаа үзүүлсэн.

Цаашид малчдад зориулсан сургалт, зөвлөгөө, малыг эрүүлжүүлэх, малчдыг ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй танилцуулах, харьцуулсан судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлууд хийгдэнэ.

4.3 Текстилийн салбарын ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дасгал ажил #4

Сургалтаар олж авсан текстилийн салбартай холбоотой мэдлэгээ ашиглан текстилийн салбарт зориулсан зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд багаар ажиллуулах.

Заавар

“НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ”

Сургалтын оролцогчид багуудад хуваагдан өмнөх модулиудаар олж авсан текстилийн салбарын онцлог²⁰, текстилийн салбарын удирдамж, текстилийн салбарын БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлал²¹, текстилийн салбарт ногоон зээл олгох шалгуур ба

²⁰ [Модуль1 Хавсралт материал](#)

²¹ [Модуль2 Хавсралт материал](#)

аргачлал²², текстилийн салбарын ногоон санхүүжилтийн зах зээлийн эрэлтийн судалгаатай холбоотой мэдлэг, гарын авлага, материалуудыг ашиглан текстилийн салбарт зориулсан дараах 3 төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд багаар ажиллана. Үүнд:

Баг 1, 2: Текстилийн салбарт зориулсан ногоон бизнесийн зээл

Баг 3, 4: Текстилийн салбарт зориулсан ногоон эргэлтийн хөрөнгийн зээл

Баг 5, 6: Малчдын ногоон хэрэглээний зээл

Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхдээ доор өгөгдсөн маягтын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд нэмэлтээр шинэ мөр нэмж, дэлгэрэнгүй мэдээлэл оруулах боломжтой. Сургалт зохион байгуулагчид дасгал ажлын талаарх мэдээллийг сургалтын эхний өдрийн төгсгөлд танилцуулах бөгөөд багууд сургалтын 2 дахь өдрийн сургалтын 11:00 цагаас багийн ажлын үр дүнд гарсан зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг бусдадаа танилцуулна. Нэг багийн танилцуулга хийх хугацаа 10 минут байна.

1. Ерөнхий мэдээлэл	
Багийн нэр:	Сонгосон зээлийн бүтээгдэхүүн:
	<input type="checkbox"/> Текстилийн салбарт зориулсан ногоон бизнесийн зээл <input type="checkbox"/> Текстилийн салбарт зориулсан ногоон эргэлтийн хөрөнгийн зээл <input type="checkbox"/> Малчдын ногоон хэрэглээний зээл
Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхтэй холбоотой дагаж мөрдөх холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын болон дотоод журмууд:	
<i>Жишээ нь:</i> <ul style="list-style-type: none"> ▪ Иргэний хууль, банкны тухай хууль, банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль ▪ Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомж ▪ Банкны, ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны ерөнхий журам ▪ Санхүүгийн байгууллагад тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх журам г.м 	
Зээлийн бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томъёоны тайлбар:	
<i>Жишээ нь:</i> <ul style="list-style-type: none"> ▪ Ногоон тоног төхөөрөмж гэж: 	

²² [Модуль3 Хавсралт материал](#)

<ul style="list-style-type: none"> ▪ Тогтвортой аргаар бэлтгэсэн түүхий эд гэж; ▪ Ногоон барилга гэж;
<p>2. Зээлийн зориулалт</p> <p>Текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлалд дурдсан 8 зориулалтыг харгалзан сонгогдсон зээлийн бүтээгдэхүүний зориулалтыг тодорхойлоорой.</p>
<p>3. Зээлийн нөхцөл</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зээлийн хэмжээ ▪ Зээлийн хугацаа ▪ Зээлийн хүү ▪ Урьдчилгаа төлбөр ▪ Зээлийн үйлчилгээний шимтгэл ▪ Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа ▪ Батлан даалт ▪ Санхүүжүүлэхээс татгалзсан үйл ажиллагааны жагсаалт
<p>4. Зээлдэгчид тавигдах шаардлага</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хуулийн этгээдэд тавигдах шаардлага ▪ Бизнесийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага ▪ Санхүүгийн чадварт тавигдах шаардлага
<p>5. Зээлийн барьцаа</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зээлийн барьцааны төрөл ▪ Барьцаа шаардах нөхцөл (санхүүжилтийн дүн, зээлийн зориулалт, бизнесийн ү.а-с хамааран)
<p>6. Зээл хүсэгчийн бүрдүүлэх материал</p> <ul style="list-style-type: none"> ▪ Иргэний бүрдүүлэх материал ▪ Хуулийн этгээдийн бүрдүүлэх материал ▪ Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бүрдүүлэх материал ▪ Санхүүгийн чадвартай холбоотой бүрдүүлэх материал ▪ Барьцаа хөрөнгөтэй холбоотой бүрдүүлэх материал
<p>7. Зээл судлах, олгох, эргэн хянах, эргэн төлүүлэх процесс</p> <p>Дараах үе шат тус бүрд хамаарах процессыг тодорхойлно уу, ингэхдээ “ногоон” зээлийн бүтээгдэхүүн гэх ойлголтыг дахин анхаараарай.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зээлийн өргөдөл хүлээн авах ▪ Зээлийн судалгаа хийх ▪ Зээлийн дүгнэлт гаргах ▪ Зээлийн шийдвэр гаргах ▪ Зээлийн гэрээ байгуулах ▪ Зээл олгох ▪ Зээлийн хувийн хэрэг бүрдүүлэлт, баримтжуулалт ▪ Зээлийн хяналт ▪ Зээлийн эргэн төлөлт

- *Зээлийн үр дүнг тайлагнах*

8. Зээлийн бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, сурталчлах болон үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтран оролцох шаардлагатай байгууллагын бусад нэгжүүд, гадаад оролцогч талууд

- *Маркетингийн хэлтэс*
- *Зээлийн газар*
- *Ногоон зээлийн алба*
- *Эрсдэлийн газар*
- *Тусгай активын алба*
- *ToC Холбоо*
- *Монголбанк*
- *Санхүүгийн зохицуулах хороо г.м*

9. Бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх идэвхжүүлэлтийн аргачлал, стратеги, төлөвлөгөө

- *Зорилтот харилцагч*
- *Маркетингийн суваг*
- *Идэвхжүүлэлтийн аргачлал*
- *Идэвхжүүлэлтийн төлөвлөгөө г.м*

9. Хариуцлага

Дараах талууд ямар ямар хариуцлага хүлээх вэ гэдэг талаас бичнэ үү.

- *Ногоон зээл авсан зээлдэгч*
- *Ногоон зээл олгосон санхүүгийн байгууллага*
- *Бусад этгээд*

Дэлгэрүүлж судлах материал, холбоос

ToC Холбоо, 2020. Нэхмэлийн салбарын тогтвортой санхүүжилтийн удирдамж.
<http://www.toc.mn/post/111>

ToC Холбоо & Гэрэгэ Партнерс, 2019. Монголын текстилийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа, *STeP EcoLab төсөл*.

ToC Холбоо, 2021. МУ-ын текстилийн салбарт ногоон зээл олгох аргачлал.
<http://www.toc.mn/post/125>

ToC Холбоо, 2019. Монгол Улсын Ногоон таксономи.
<http://toc.mn/ufiles/uploaded/files/1600244565177.pdf>

ToC Холбоо & GIZ , 2020. Эрчим хүчний үр ашгийн шалгуур үзүүлэлт. Зээлийн үйл ажиллагаанд зориулсан эрчим хүчний үр ашгийн гарын авлага.
<http://toc.mn/ufiles/uploaded/files/1598597265174.pdf>

Монголын Ноос Ноолуурын Холбоо. <http://www.mongoltextile.mn/web/nav/79>

Ногоон алт төсөл. <https://www.greenmongolia.mn/мөшгөх-тогтолцоо>

Тогтвортой ноолуурын холбоо. 2020. Тогтвортой ноолуурын гэрчилгээ.
<https://www.sustainablecashmere-mongolia.com/wp-content/uploads/2020/11/Certification-2020-.pdf>

<https://www.avsf.org/fr/posts/1742/full/une-filiere-de-fibre-de-cachemire-durable-en-mongolie>

ХХАХҮЯам. 2018. Ноолуур хөтөлбөр (2018-2021).
<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol27.pdf>

ХХАХҮЯам. 2019. Ноос ноолуурын бүтээгдэхүүний үйлвэрлэл.
<https://mofa.gov.mn/exp/blog/11/175>